# “ЛОРО ПЬЯНА МОНГОЛ” ХХК -ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 03-Р ХОРООНД ХЭРЭГЖИЖ БУЙ “ХИМИ БОЛОН БИОЛОГИЙН АРГААР БОХИР УС ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

РД: 2046237

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЛОРО ПЪЯНА МОНГОЛ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

А.БУЯНДЭЛГЭР

**ХЯНАСАН:**

НБОГ-ЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

О.ТЭМҮҮЖИН

НБОГ-ЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.СҮХЦООЖ

БИЕЛЭЛТИЙГ ГАРГАСАН:
“ЛОРО ПЪЯНА МОНГОЛ” ХХК-ИЙН ХАБЭА-н БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

Л.СОДХҮҮ

**УЛААНБААТАР ХОТ**
**2024 ОН**




# “ЛОРО ПЬЯНА МОНГОЛ” ХХК -ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 03-Р ХОРООНД ХЭРЭГЖИЖ БУЙ “ХИМИ БОЛОН БИОЛОГИЙН АРГААР БОХИР УС ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

РД: 2046237

УЛААНБААТАР ХОТ, 2024 ОН

# ГАРЧИГ

*НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА* ........ 3

***1.1. Төслийн ерөнхий мэдээлэл*** ........ 3

***1.2 Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил*** ........ 10

*ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ* ........ 11

*2.1 Цаг уур* ........ 11

*2.2 Агаарын чанар* ........ 11

*Агаар бохирдуулах бодисын тооллого хийх* ........ 12

*2.3 Гадаргын болон гүний ус* ........ 15

*2.4 Хөрсөн бүрхэвч* ........ 18

*2.5 Ургамлан нөмрөг* ........ 20

*2.6 Амьтны аймаг* ........ 20

*2.7 Түүх соёлын дурсгалт газрууд* ........ 21

*2.9 Нийгэмд эдийн засаг* ........ 23

***Хан-Уул дүүргийн газар нутаг*** ........ 23

***Хан-Уул дүүргийн засаг захиргаа*** ........ 24

***Боловсрол, соёл шинжлэх ухаан*** ........ 25

***Эрүүл мэнд*** ........ 25

*ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ* ........ 26

*3.1 Төслийн барилга байгууламжийг өргөтгөн барьж байгуулах үеийн гол нөлөөлөл* ........ 28

*3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл* ........ 29

*3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл* ........ 29

*3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл* ........ 31

*3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл* ........ 31

*3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл* ........ 32

*3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл* ........ 32

*3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл* ........ 33

*3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл* ........ 34

*3.10 Хуримтлагдах нөлөөлөл* ........ 34

*ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ* ........ 36

*ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ* ........ 37

*ЗУРГАА.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ* ........ 40

*ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ* ........ 41

*НАЙМ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ* ...... *42*
*ЕС.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ* ...... *43*
*АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР* ...... *44*
*АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ* ...... *46*
*АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ* ...... *46*

## ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

*Хүснэгт 1. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил* ...... 11
*Хүснэгт 2. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн* ...... 12
*Хүснэгт 3. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн* ...... 12
*Хүснэгт 4. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн* ...... 12
*Хүснэгт 5. Агаар бохирдуулагч бодис* ...... 13
*Хүснэгт 6. Параметрийн утга* ...... 14
*Хүснэгт 7. Шороон замаас үүсэх тоосонцрын ялгаралт* ...... 14
*Хүснэгт 8. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл* ...... 18
*Хүснэгт 9. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт* ...... 18
*Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн* ...... 19
*Хүснэгт 11. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар* ...... 19
*Хүснэгт 12. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж* ...... 19
*Хүснэгт 13. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа* ...... 26
*Хүснэгт 14. Гол нөлөөллийн дүн шинжилгээ* ...... 26
*Хүснэгт 15. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ* ...... 30
*Хүснэгт 16. Автомашины утааны бүрдэл найрлага* ...... 30
*Хүснэгт 17. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл* ...... 35
*Хүснэгт 18. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө* ...... 37

## ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

*Зураг 1. Төслийн байршил* ...... 7
*Зураг 3. Хур тунадасны үзүүлэлт* ...... 11
*Зураг 2. Уур амьсгалын үзүүлэлтүүд* ...... 11
*Зураг 4. Автомашинаас ялгарах хаягдлын тархалт* ...... 13
*Зураг 5. Гадаад тээвэрлэлтээс үүсэх тоосонцрын тархалт* ...... 15
*Зураг 6. Туул голын сав газар* ...... 16
*Зураг 7. Богдхан уулын амьтны аймаг* ...... 21
*Зураг 8. Горхи – Тэрэлжийн БЦГ* ...... 22
*Зураг 9. Богдхан уулын ДЦГ* ...... 23
*Зураг 10. Төслийн талбайн 1 км-ийн эргэн тойронд* ...... 34

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Манай компанид Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 сарын 21-ны өдрийн А/1589 тоот захирамжаар Хан-Уул дүүргийн 03-р хорооны нутагт “үйлдвэрлэл, үйлчилгээ” зориулалтаар 10989.0 мкв газрыг 5 жилийн хугацаатай сунгаж эзэмших эрхийн гэрчилгээ олгосон.

| Нэг. Ерөнхий мэдээлэл | | |
|---|---|---|
| 1.1 | **Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл** | “Лоро пьяна монгол” ХХК<br>РД: 2046237 |
| 1.2 | **Төсөл хэрэгжүүлэгчийн байршил** | Улаанбаатар хот, Хан-Ууд дүүрэг, 03-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Өөрийн байр 00тоот. Утас: 99194874 |
| **Хоёр. Төслийн талаарх мэдээлэл** | | |
| 2.1 | **Төслийн нэр** | “Лоро пьяна монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төсөл |
| 2.2 | **Төслийн байршил** | “Лоро пьяна монгол” ХХК-ийн төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 03-р хорооны нутаг дэвсгэр байрлана.<br><br>Газрын байршил нь үйлдвэрлэлийн районд оршдог бөгөөд орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 1.0 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн |

| | | |
|---|---|---|
| | | эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна. |
| **2.3** | **Төслийн зорилго** | Ноолуурын анхан шатны боловсруулалтыг хийн Итали улс руу “Лоро пьяна монгол” ХХК нь экспортлон захиалагчид нийлүүлэх зорилготой. |
| **2.4** | **Төслийн ерөнхий төлөвлөгөө** |   Үйлдвэрийн дотор талын шал нь 20 см зузаан цементэн хучилттай, резинэн будагтай. |
| **2.4** | **Төслийн хүчин чадал** | - Төсөлд одоогоор нийт 40 хүн ажиллаж байна.<br>- Сард 20 тонн, жилд 240 тонн ноолуур боловсруулна.<br>- Төслийн агуулахад1 төрлийн химийн бодис хадгална. /Саван/ |
| **2.5** | **Төслийн хог хаягдал** | **Хатуу хог хаягдал:**<br>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 12 кг, жилд 4.38 тн орчим хаягдал гарах бөгөөд харъяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна.<br>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.<br>- Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт<br>- Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд<br>- Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны |

хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батарей зэргүүд хамаарна.

***Төслийн талбайн хог хаягдлын цэгийг зурагт харуулав***




*Төслийн талбайн гадна, дотор талын хог ангилан хаядаг.*



**Шингэн хог хаягдал:**

Нийт 40 ажилтантай гэж үзвэл унд ахуйн усны хэрэглээ хоногт 8 м$^3$, технологийн усны хэрэглээнд хоногт 27м$^3$ жилд амралт баяр ёслолын өдрийн хасаад 350 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 12250 м$^3$/жил болно

Үүнээс:

Төслөөс гарсан бохир усны 80 хувийг цэвэршүүлэн эргэлтийн системээр дахин ашигладаг. Үлдсэн 20 хувь цэвэршүүлсэн бохир усыг төвийн бохир усны шугам руу нийлүүлдэг.

Энэ жил нэмэлтээр биологийн аргаар үйлдвэрийн саарал усыг цэвэршүүлэх MBR систем бүхий цэвэршүүлэх байгууламж нэмж барина.

| | | |
|---|---|---|
| | | <br>**Хийн хаягдал:**<br>Үйлдвэрийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.<br>Үйлдвэрийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт **481.7 тн** дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, CO-0.000148 тн, нүүрстөрөгч–0.000445 тн, $NO_2$–0.00005927 тн, $SO_2$-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хорт хий ялгарахаар байна. |
| **2.6** | **Ариун цэврийн байгууламж** | Үйлдвэрийн хувьд байран дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай. Зургийг оруулав.<br> |

| | | |
|---|---|---|
| **2.7** | **Усан хангамж** | Үйлдвэрийн газрын цэвэр усны хангамжийг төвийн цэвэр усны шугамнаас авдаг. Ус сувгийн гэрээтэй. |
| **2.8** | **Цахилгаан хангамж** | Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний хүчдэлийн шугамаас трансформатор байгуулсны үндсэн дээр эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Зориулалт бүхий шонгуудыг газарт суулган бэхлэж, цахилгааны утас татах, дэд станц байрлуулах, цахилгааны шугамны гадна ба дотор талын холболтын ажлыг тусгайлсан зураг гаргаж, мэргэжлийн хүмүүсээр өндөр түвшинд гүйцэтгүүлсэн. |
| **2.9** | **Дулаан хангамж** | Тус байгууламж нь төвийн дулааны шугамд холбогдсон. |




*Зураг 1. Төслийн байршил*




*Төслийн харагдах байдал №1*



*Төслийн талбайн ногоон байгууламжийн харагдах байдал №2*



*Төслийн талбайн самнах цех болон галын аюулгүй байдлын булан*



*Төслийн ажилчдын гал тогоо, хоолны хэсэг болон ноолуур пресслэх цех*

“Лоро пьяна монгол”ХХК-ийн төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 03 -р хорооны Чингисийн өргөн чөлөөний гудамж, Өөрийн байрны нутаг дэвсгэрт байрлана.

Тус төслийн ойр тойронд үйлдвэрийн район үргэлжилдэг. Тус газар нь антропогены хүчин зүйлийн улмаас дунд зэргийн талхагдалд өртсөн, хөрс ургамал их зэрэг талхлагдсан газар, бетондсон байна.

### *1.2 Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил*

***Цахилгаан хангамж***: Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний хүчдэлийн шугамаас трансформатор байгуулсны үндсэн дээр эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Зориулалт бүхий шонгуудыг газарт суулган бэхлэж, цахилгааны утас татах, дэд станц байрлуулах, цахилгааны шугамны гадна ба дотор талын холболтын ажлыг тусгайлсан зураг гаргаж, мэргэжлийн хүмүүсээр өндөр түвшинд гүйцэтгүүлсэн.

***Дулаан хангамж:*** Тус байгууламж нь төвийн дулааны шугамтай холбогдсон.

***Замын тэмдэгжүүлэлт***: Автомашины тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу шаардлагатай байршилд суурилуулах шаардлагатай.

***Цэвэр болон бохир усны хоолой:*** Төвийн шугамтай холбогдсон.

# ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## *2.1 Цаг уур*

Төсөл хэрэгжих орчимд эх газрын уур амьсгалын онцлогоос болоод жилийн хүйтэн улиралд агаарын температур газар өндөрсөх тутам дулаарах, харин дулаан улиралд газар өндөрсөх тутам сэрүүсдэг байдал энд тодорхой харагдаж байгаа бөгөөд “хотын дулаан арал” тод илэрч байдаг онцлогтой.

*Зураг 2. Уур амьсгалын үзүүлэлтүүд*




*Зураг 3. Хур тунадасны үзүүлэлт*




Аливаа төслийн төлөвлөлтөнд тухайн төсөл хэрэгжих орчны байгаль цаг уурын онцлог, уур амьсгалын хүчин зүйлийг судалж, нарийн сайн тооцоолох хэрэгтэй. Харин тус төслийн хувьд хэрэгжих орчин нь эрс тэс уур амьсгалтай, агаарын болон хөрсний температур сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай, тухайн орчны агаарын хуурайшилт эрчимжиж байна. Хавар, намрын улиралд салхины хурд ихэсч, шороон шуургын давтамж нэмэгдэх, салхины нөлөөгөөр ууршилт нэмэгдэж, хуурайшилт эрчимжихийг цаашдын үйл ажиллагааны төлөвлөлтөнд харгалзан үзэх шаардлагатай.

## *2.2 Агаарын чанар*

Төслийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд

*Хүснэгт 1. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил*

| Агаар | | Координат | Цэг сонгосон үндэслэл | Дээж авч буй фото зураг |
|---|---|---|---|---|
| 1 | 1-р цэг | | Өмнө хийгдсэн хяналт-шинжилгээний үр дүнтэй харьцуулах |  |

***Хяналт шинжилгээний үр дүн***

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хэвийн хэмжээнд байна.

*Хүснэгт 2. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн*

| № | Сорьц авсан цэг | Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/ |
|---|---|---|
| 1 | Ажлын талбай | 0.150 |
| 2 | Гадна талбай | 0.124 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016** | | **0.500** |

***Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт***

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

*Хүснэгт 3. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн*

| № | Сорьц авсан цэг | $NO_2$ (*Азотын давхар исэл мг/м*$^3$) | $SO_2$ (*Хүхэрлэг хий мг/м*$^3$ ) |
|---|---|---|---|
| 1 | Ажлын талбай | 0.066 | 0.065 |
| 2 | Гадна талбай | 0.085 | 0.115 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016** | | **0.200** | **0.450** |

***Дуу шуугианы хэмжилт***

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын 2 цэгийн ойр орчимд хэмжсэн ба 16 цагийн дундаж үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

*Хүснэгт 4. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн*

| № | Сорьц авсан цэг | Дуу чимээ дБ (А) |
|---|---|---|
| 1 | Ажлын талбай | 56 |
| 2 | Гадна талбай | 52 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 дБ (А), 16 цагийн дундаж** | | **60** |

***Агаар бохирдуулах бодисын тооллого хийх***

2019 онд БОАЖЯ-наас гаргасан Агаар бохидуулах бодисын хаягдлын тооллого хийх аргачлалыг ашиглаж хялбарчилсан аргаар автомашинаас ялгарах хаягдлыг тооцох, шороон замаас дэгдэх тоосонцрын хаягдлын коэффициентыг тооцов.

*Хялбарчилсан аргаар автомашинаас ялгарах хаягдлыг тооцох*

Шланзны шатахуун зарцуулалт 17.5 л/цаг, бага оврын ачааны машины шатахуун зарцуулалт нь 12.5 л/цаг байна. Эдгээр тээврийн хэрэгсэл тус бүрийн хийн ялгаралтыг дараах томьёогоор тооцно. Эдгээр нь машинууд нь дизель учраас зарцуулалтын хэмжээ бага оврын ачааны машины хувьд 57.5 гр/км, том оврын шланзын хувьд 240 гр/км байна.

$$E = EF * EC$$

Энд

E- тухайн бодисын ялгаралтын хэмжээ, гр
EF- бохирдуулагчийн ялгаралтын фактор, гр/кг
EC- түлш зарцуулалт, кг

Ачаа ачсан шланз 60 км/цаг хурдтай явахад түлш зарцуулалт нь 611.8 гр/км * 60 км/цаг = 36,708 гр/цаг буюу 36.7 кг/цаг юм.

*Хүснэгт 5. Агаар бохирдуулагч бодис*

| № | Бодисын нэр | Нэгж ялгаралт, гр/кг | Ялгаралтын хэмжээ, гр/с | |
|---|---|---|---|---|
| | | | Шланз | Hinno 20 тн даацтай |
| 1 | Нүүрстөрөгчийн исэл | 7.58 | 0.051 | 0.118 |
| 2 | Азотын давхар исэл | 33.37 | 0.222 | 0.519 |
| 3 | Нүүрстөрөгч | 3169 | 21.127 | 49.296 |
| 4 | Хүхэрлэг хий | 0.003 | 0.000 | 0.000 |
| 5 | Хөө тортог | 1.92 | 0.013 | 0.030 |
| 6 | Хар тугалга | 0.000052 | 0.000 | 0.000 |

Тухайн тээврийн хэрэгсэл тус бүрийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хийн хаягдлын оронзайн тархах тархалтыг бохирдуулагч бодис тус бүрээр тооцоолоход NOx-оос бусад элементийн хувьд зөвшөөрөгдөх агууламжаас бага байна. NOx-ийн агууламж 15 м зайд 49 мкг/$м^3$ буюу зөвшөөрөгдөх агууламжтай тэнцүү болно.

*Зураг 4. Автомашинаас ялгарах хаягдлын тархалт*




*Шороон замаас дэгдэх тоосонцрын хаягдлын коэффициент тооцох*

Шороон замаар тээвэрлэлт хийх үеийн PM10 тоосонцрын ялгаралтын хэмжээ нь хээрийн хэмжилтийн үр дүнтэй шугаман хамааралтайг доорх тэгшитгэлээр үзүүлсэн байна.

$$E = k\left(\frac{s}{12}\right)^{a}\left(\frac{W}{3}\right)^{b}$$

E - ялгаралтын хэмжээ, (lb/VMT)
s - гадаргуугийн тоосонцрын агууламж, (%)
W - тээврийн хэрэгсэлийн жин, тонн

K, a, b - эмпирик тогтмолууд /Guidance on Estimating Road Dust Emissions from Industrial Unpaved Surfaces/

Ялгаралтын хэмжээ нь 1mile тээвэрлэлт хийхэд ялгаруулах тоосонцрын / 1lb/ хэмжээг илэрхийлдэг. Нэгжийг 1 гр/м-с хөрвүүлж дараах байдлаар бичив.

$$E = \frac{1.36}{u}k\left(\frac{s}{12}\right)^{a}\left(\frac{W}{3}\right)^{b}$$

U - тээврийн хэрэгсэлийн хурд, м/с

*Хүснэгт 6. Параметрийн утга*

| Тогтмол | $PM_{2.5}$ | $PM_{10}$ | TPM |
|---|---|---|---|
| k | 0.042 | 0.423 | 1.381 |
| a | 0.9 | 0.9 | 0.7 |
| b | 0.45 | 0.45 | 0.45 |

Тээврийн хэрэгслийн дундаж хурд 50 км/цаг буюу 13.8 м/с, машины жин 20 тн байна. Шороон замаас авсан шинжилгээний дүнгээр тоосонцрын агууламж 39.5% бөгөөд энэ утга нь тээвэрлэлтийн нөлөөнд бага өртсөн шороон замаас авсан дээжийн үр дүн юм. Хэрвээ тээвэрлэлтийн нөлөө ихсэж хөрс элэгдэлд орсноос хөрсөнд агуулагдах тоосонцрын хэмжээ нэмэгдвэл ялгаралтын хэмжээ шугаман хамаарлаар нэмэгдэнэ.

*Хүснэгт 7. Шороон замаас үүсэх тоосонцрын ялгаралт*

| Үзүүлэлт | PM2.5 | PM10 | TPM |
|---|---|---|---|
| Ялгаралт, гр/м-с | 0.041 | 0.41 | 1.06 |

Шугаман эх үүсвэрээс агаарт тархах бохирдуулагч бодисын агууламжийг дараах томьёогоор олов / (Gilbert, 2003)/.

$$C(x) = \frac{2q}{\sqrt{2\pi}\sigma_z u}$$

C(x) - тоосонцрын агууламж, мгр/м$^3$
q - ялгаралтын хэмжээ, гр/м-с
σz - дисперсийн параметр
u - салхины хурд, м/с

*Зураг 5. Гадаад тээвэрлэлтээс үүсэх тоосонцрын тархалт*




Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж 300 м зайд 103 мкг/м$^3$ байна.

***Дүгнэлт, зөвлөмж***

Төслийн эзэмшил талбай болон гадна талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

## *2.3 Гадаргын болон гүний ус*

Хан-Уул дүүргийн 03-р хороо нь Монгол орны гадаргын усны сүлжээний томоохон төлөөл Туул голын сав газрын дунд хэсэг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт, Туул голын зүүн эргээс хойд зүгт оршино. Туул голын сав газарт гидрологи, гидрогеологийн сэдэвчилсэн шинжилгээ, судалгааны ажил өргөн хүрээтэй хийгдсэн бөгөөд ялангуяа ус судлалын Туул-Улаанбаатар харуулын мэдээ материалыг ашигласан бүтээл цөөнгүй байдаг ба эдгээр бүтээл болон эх мэдээг гидрологийн хэсэгт ишлэл болгов.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн гадаргын ус:

- Гол горхи 48 үүнээс байнгын урсацтай 22, түр зуурын урсацтай 25, ширгэсэн 1;
- Булаг шанд 120 үүнээс байнгын ундаргатай 87, шургадаг 27, ширгэсэн 9, хашиж хамгаалсан 30 , хамгаалах шаардлагатай 39;
- Рашаан 14 байнгын ундаргатай 12, шургадаг 2, хашиж хамгаалсан 7, хашиж хамгаалах шаардлагатай 1;
- Нуур цөөрөм 8, байнгын устай 7, ширгэсэн 1, хашиж хамгаалсан 2;

Улаанбаатар орчмын газрын доорхи ус нь статик, динамик гэсэн 2 үндсэн төрлийн нөөцөөс бүрдэнэ. Статик нөөц нь ус агуулагч бүрдэл, бүсийн нүх сүв, ан цавын хэмжээ ус өгөмжөөс хамаарна. Динамик нөөц нь аэроцийн бүсийн ус нэвтрүүлэх чадвар, гадаргын

усны урсац, хур тунадасны хэмжээ зэрэг тэжээгдлийн үзүүлэлтүүдээс ихээхэн хамаарч байдаг. Хот орчмын газрын доорхи усны ихэнхи статик, динамик нөөц Туул голын Хөндий дагасан Орчин үеийн дөрөвдөгч –Дээд дөрөвдөгчийн настай аллювийн хурдас дахь устай бүрдэл юм. Статик, динамик нөөц хязгаарлагдмал шинжтэй тархсан.

Статик нөөц өвлийн улиралд зонхилон ашиглагдаж, усны түвшин доошилж, усны нөөцийн хомсдол жил бүрийн өвлийн адаг, хаврын эхний саруудад үүсдэг. Динамик нөөц нь хаврын эхэн үеэс гадаргын ус, газар гэсэх үеэс эхлэн газрын гэссэн хөрс рүү гадаргын ус шингэж, богино хугацааны дотор хомсдолд өртсөн статик нөөцийг нөхөж газрын доорхи усны түвшинг дээшлүүлж зун, намрын улиралд газрын доорхи усны ашиглалтын нөөцийг бүрдүүлж байдаг.

Улаанбаатарын орчимд тархсан Туул голын хөндий нь газрын доорхи усны тэжээгдэл, хуримтлал, хөлийн бүс болж, Чингэлтэй, Баянзүрх, Богд Сонгино Хайрхан уулс нь газрын доорхи усны тэжээгдлийн бүс болж уулархаг хэсэгт үүссэн динамик нөөц Туулын хөндий дэх газрын доорхи усаа тэжээдэг тал бас бий.

### 4.2 Төсөл хэрэгжих орчны гадаргын усан орчин

Улаанбаатар хотын гадаргын ус зүйн горим: Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь Дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Монгол орны 29 голын сав газрын Туул гол болон Хараа голын сав газарт хамаарагддаг. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадаргын усан сүлжээ нэлээд сайн хөгжсөн байдаг. Тухайлбал, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамгийн том гадаргын усан сүлжээний илэрц нь Туул гол бөгөөд Туул гол руу цутгадаг жижиг голуудыг дурьдвал Өвөр горхи, Дэнд, Гачуурт, Улиастай, Хөл, Сэлбэ, Толгойт, Түргэн зэрэг голууд юм.

*Зураг 6. Туул голын сав газар*




Голын сүлжээний нягтшил голын эх өөд 0.05-0.1 км/км2 байдаг бол дунд ба адаг хавьдаа 0.01-0.05 км/км2 болтол буурна. Гол мөрний олон жилийн дундаж урсац сүлжээний

нягтшилыг дагаж уул хэсэгтээ 150-200 мм, урсац сарних заагт 50-100 мм, гадаргын буюу үерийн урсац 100-150 мм, ай савын хөрсний нийт чийгшил уулын өндрөөс нам руугаа буурч 150-200 мм, хөрсний гадаргаас ууршиx ууршилт 200-250 мм, уст гадаргаас ууршиx ууршилт 600-800 мм-ийн хооронд хэлбэлзэнэ. Гол горхины үндсэн тэжээл нь хур бороо (69%), ул хөрсний ус (25%), хайлсан цас мөсний ус (6%) бөгөөд хаврын шар ус, зуны хур борооны үертэй гол мөрний ангилалд хамаарна.

Туул голын тэжээлийн 25%-ийг ул хөрсний ус, 6%-ийг хайлсан цасны ус, 69%-ийг хур борооны ус эзлэх ба усны горимын хэв шинж нь хаврын шар усны ба зуны хур борооны үеийн горимтой голд хамаарна. Туул голын урсац бүрдүүлэх үндсэн хүчин зүйл бол хур тунадас болно. Туул голын усны үндсэн тэжээл зун, намрын хур бороо болохоор усны түвшин ихээхэн тогтворгүй байдаг. 4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч үргэлжлэх хугацаа, урсцын хэмжээгээр бага юм. Хаврын шар усны үерийн дараагаар нэг хэсэгтээ зуны гачиг үе ажиглагдах бөгөөд 7-9 дүгээр сар хүртэл зун, намрын борооны үер залгаснаар голын усны түвшин эрс дээшилнэ.

Борооны үерийн их түвшин шар усны үерийн түвшингээс 1.5-2.0 дахин их байдаг. Хур борооны үер дууссаны дараа мөсний үзэгдэл үүсэх хүртэл усны түвшин аажим буурч өвлийн гачиг үе эхлэнэ. Голын мөсний үзэгдэл 10 дугаар сарын сүүлчийн арав хоногт эхэлж, 11 дүгээр сарын хоёрдугаар арав хоногт бүрэн хадаалан 4 дүгээр сарын сүүлч хүртэл 122 хоног мөсөн бүрхүүлтэй байна. Аливаа голын олон жилийн дундаж урсцыг тооцохдоо тухайн голын их ба бага услагтай жилүүдийг хамарсан нэг буюу нэгээс дээш бүтэн үеллээр тооцдог бөгөөд энэ нь магадлалын онолын үүднээс тухайн байгалийн процессын олон жилийн бодит утгад ойртсон гэж үздэг.

**Төсөл хэрэгжих талбайн хувьд:**

Уг төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 03-р хороонд хэрэгжиж байгаа бөгөөд цэвэр болон бохир усан хангамжийн хувьд төвийн шугамаас авч хангадаг. /Хаягдал усны шинжилгээ, зөвшөөрөл дүгнэлтийг хавсаргав/ Усны шинжилгээний дүнгээр химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт MNS900:2005” –ын шаардлага хангаж байна.

4.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Гүний ус нь нөхөн сэргээгдэхэд хугацаа удаан шаарддаг тул ажилчид болон үйлчилгээний усны хэрэглээнд усаа хэмнэх оновчтой шийдэл гаргах
- Ашигласан усыг дахин ашиглах технологийг жил бүр засварлаж сайжруулж байх шаардлагатэй
- Бохир ус болон цэвэр усны тагийг ялгах тэмдэгжүүлэлт хийх

### *2.4 Хөрсөн бүрхэвч*

Энэхүү бүлэгт Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 03-р хорооны нутагт орших 10989 м2 төслийн газарт хийсэн хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнг тусгав.

***Судалгааны үр дүн***

Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн муж, Хэнтийн захын тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009).

***Зүсэлт №1***

*Хүснэгт 8. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл*

| Хөрсний морфологи бичиглэл | | |
|---|---|---|
| *Хөрсний зүсэлтийн дугаар* | | Зүсэлт №1 |
| *Байршил* | | Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 03-р хороо |
| *Өндөр* | | д.т.д 1269,5 метр |
| *Газрын гадарга* | | $1^0$ |
| *Ургамлын бүрхэвч* | | 20% |
| *Хөрсний нэр* | | Хар хүрэн хөрс |
| *Хөрсний фото* 20-р хороо | *Гүн* | Морфологи шинж чанар |
|  | **А.** 0 -20<br>20 см | Хар хүрэн өнгөтэй, хуурай, нягт, ургамлын үндэс эзлэхүүний 10%, үйрмэг чулуу эзлэхүүний 20%, шилжилт өнгө байна. |

*Хүснэгт 9. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт*

| Зүсэлт | Гүн, см | pH $H_2O$ | ЦДЧ, dS/m | Давс | Ялзмаг % | Ca $CO_2$, % | Солилцох суурь, мг-экв/100 гр | | | Шим тэжээлийн элементүүд мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ca+ Mg | Ca | Mg | $P_2O_5$, | $K_2O$ |
| 1 | 0-20 | 8.40 | 0.114 | 0.06 | 1.00 | 0.30 | 13.1 | 10.4 | 2.7 | 1.6 | 14 |

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь дунд шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ дунд зэрэг, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй, солилцох сууриас Ca хангалттай, Mg хангалттай агууламжтай мөн хөдөлгөөнт фосфор, калийн агууламж бага байна. Хөрсний үржил шимийн түвшин бага байна.

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

*Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн*

| Зүсэлт | Гүн, см | Механик бүрэлдэхүүн, % ширхгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 0-20 | 52.2 | 29.5 | 7.9 | 1.9 | 6.3 | 2.2 | 10.5 |

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

*Хүснэгт 11. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар*

| Хөрсний шинж чанарын үзүүлэлт | | Механик бүрэлдэхүүн | | |
|---|---|---|---|---|
| | | Элсэнцэр ба хөнгөн шавранцар | Дунд шавранцар | Хүнд шавранцар, шавар |
| 1 | Боловсруулалт | + + | + | - - |
| 2 | Тэжээлийн бодис агуулалт | - - | + | + + |
| 3 | Ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт | - | + + | + |
| 4 | Хоруу бодисын хуримтлал | - | + + | + + |
| 5 | Ус агуулалт | - - | + + | + + |
| 6 | Ургамал ус нийлүүлэлт | - | + | - |
| 7 | Механик шүүлт | + | + | - |
| 8 | Физик-химийн шүүлт | - - | + + | + |
| 9 | Ус шүүлт | + + | 0 | - - |
| *++маш сайн (дээд зэрэг), + сайн (өндөр), 0 хангалттай (дунд зэрэг), - тааруу, - - нэн хангалтгүй | | | | |

Дээрх хүснэгтээс үзэхэд элсэнцэр ба хөнгөн шавранцар хөрс нь тэжээлийн бодис, ус агуулалт болон физик химийн шүүлт нэн хангалтгүй, ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт, хоруу бодисын хуримтлал, ургамлын ус нийлүүлэлтээр тааруу харин механик шүүлт сайн, хөрсний боловсруулалт, ус шүүлтээр маш сайн гэсэн үзүүлэлттэй байна.

***Хөрсний бохирдол***

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын 1 дээж авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 12. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж*

| № | Үзүүлэлт | Агууламж мг/кг | Хөрсний механик бүрэлдэхүүн | | | Хөрсний хүнд металлын агууламж , % | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шавар лаг | Шавран цар | Элсэрхэг | Зөвшөөр өгдөх дээд хэмжээ | Хортой агууламж | Аюултай агууламж |
| 1 | Никель (Ni) | 10.2 | **150** | 100 | 60 | 150.0 | 1000.0 | 1800.0 |
| | Кадми (Cd) | ND | **3** | 2 | 1 | 3.0 | 10.0 | 20.0 |
| | Хар тугалга (Pb) | 1.40 | **100** | 70 | 50 | 100.0 | 500.0 | 1200.0 |
| | Цайр (Zn) | 32.6 | **300** | 150 | 100 | 300.0 | 600.0 | 1000.0 |
| | Хром (Cr) | 10.2 | **150** | 100 | 60 | 150.0 | 400.0 | 1500.0 |
| | Зэс (Cu) | 24.4 | **100** | 80 | 60 | 100.0 | 500.0 | 1000.0 |

Хөрсний дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850:2019) Хөрсний чанар. Хөрс

бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх, хортой болон аюултай агууламжаас доогуур буюу хөрс бохирдолгүй байна.

### *2.5 Ургамлан нөмрөг*

Төсөл хэрэгжих газар нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Голо-арктикийн их муж, Евро-Азийн мужийн Төв Монголын хошууны Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт багтана. Энэ тойрог нь Монгол орын нутаг дэвсгэрийн 6.62%-ийг эзлэх бөгөөд 946 зүйлийн гуурст ургамал бүртгэгдсэн томоохон тойргийн нэг юм. Ургамлын аймгийн хувьд Дагуурын ойн ба уулын хээрийн төлөөлөгчдөөс, өмнөд захаараа монголын хээрийн төлөөлөгчдөөс бүрдэл болно.

Ургамлан нөмрөгт хээрийн хэвшинж давамгайлах учир экологийн даацын хувьд тийм ч өндөр биш. Ургамлан нөмрөгийн 22,5% нь 35%-иас бага, 35,5% нь 50%-иас бага тусгал бүрхэцтэй байна. Ургамал хоорондын нягтрал бага, хучлагагүй халцгай газрын эзлэх хэмжээ их байгаа нь агаарыг бохирдуулагч бодис газрын хөрсөнд шууд шингэж орох, хөрсний хуурайшлыг нэмэгдүүлэх, салхи, усны элэгдэлд нэрвэгдэх магадлалыг ихэсгэх нөхцлийг бүрдүүлж өгдөг.

Хэдийгээр Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн ургамлын зүйлийн бүлгэмдэл арвин баялаг байсан боловч хотжилт, хүн амын хэт төвлөрөл, суурьшил зэргээс шалтгаалж төрөл зүйл, тоо хэмжээ өдрөөс өдөрт буурч байна. Ургамал устаж үгүй болсон байна.

Эвдэрсэн газрыг зохих стандартын дагуу хэлбэржүүлж, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх, машин, өөрөө явагч хэрэгслийн хөдөлгөөн, нөлөөллийг тухайн тогтоогдсон зурваст байлгах арга хэмжээ авах, байгалийн унаган төрхөө хадгалсан өнгөн хөрсийг тусгайлан хуулан авч тухайн газрын ойролцоо овоолго үүсгэн хадгалж, сүүлд нь тухайн газрыг нөхөн сэргээхэд ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаануудыг цаг алдалгүй хийх хэрэгтэй.

Төслийн талбайд олон наст ургамлаар зүлэгжүүлэлт хийх, эвдэгдсэн газрыг зохих стандартын дагуу хэлбэржүүлж, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхдээ нутгийн унаган ургамлыг сонгох шаардлагатай.

### *2.6 Амьтны аймаг*

Амьтны аймгийн хувьд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот суурин амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөнтэй холбоотой.

*Зураг 7. Богдхан уулын амьтны аймаг*




Улаанбаатар хот орчмын Богдхан уул амьтны газарзүйн хувьд тайга, ойт хээр, хээр тал, ус намаг, хад асга, хот суурин, интрозиаль янз бүрийн ландшафт, амьдралын экологийн олон онцлогуудыг агуулснаараа шавьж, шувуу, хөхтөн амьтдын өвөрмөц цогцолбортой.

Амьтны аймгийн хувьд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөнтэй холбоотой. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (P.domesticus) ба хээрийн (P.montanus) бор шувуу, хөхвөр тагтаа (C.livia), Сохор элээ (Milvus migrans), Шаазгай (Pica pica), Улаан хошуут (Pyrrhcorax pyrrhocorax), Хар хэрээ (Corvus corone), Хон хэрээ (Corvus corax) арай олон үзэгдэнэ. Хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавьжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог таарална.

## *2.7 Түүх соёлын дурсгалт газрууд*

Нийслэлийн тусгай хамгаалалттай газар нутагт Хан-Хэнтий болон Богдхан уулын улсын тусгай хамгаалалттай газар нутаг хамрагдаж байна. Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь Хан Хэнтийн дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Нагалхааны байгалийн нөөц газар гэсэн хамгаалалтын гурван өөр дэглэмтэй 1 523 318 га, Богдхан уулын ДЦГ 41651 га нутаг дэвсгэрийг хамран оршдог.

## 1. Горхи – Тэрэлжийн байгалийн цогцолбор газар

Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт нийт 293168,0 га талбайг эзлэн, Улаанбаатараас зүүн тийш 50-76 км газарт байрладаг.

.




*Зураг 8. Горхи – Тэрэлжийн БЦГ*

2. Богдхан уулын Дархан цаазат газар

Богдхан Уул 1994 онд Дархан Цаазат Газраар (ДЦГ) тодорхойлогдож, 1997 онд Богдхан Уул Шим мандлын бүс (UNESCO) газраар зарлагдсан дэлхийн хамгийн эртний хамгаалалттай газар юм. Энэ уул нь Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээр, хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг.

Дархан цаазат Богдхан уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268.0 өндөрт өргөгдсөн 41348.54 га талбайг эзлэн оршдог Цэцээ гүн юм.




*Зураг 9. Богдхан уулын ДЦГ*

3. Ãандантэгчилэн хүрээ хийд îрчмын 57 га газрыг 2001 онд УИХ-ын тогтоолоор тусгай хамгаалалтанд авсан.

Нийслэлийн хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газар нутгууд:

1. "Баянзүрх хайрхан"-ыг НИТХ-ын 1997 оны 07 сарын 23-ны өдрийн 50 тоот тогтоолоор байгалийн цогцолбор газарт.

2. СХД-ийн нутаг дэвсгэр дэх Хамбын овооны Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх цогцолбор газрыг НИТХ-ын 2008 оны 09 сарын 22-ны өдрийн 141 тоот тогтоолоор орон нутгийн хамгаалалтанд авсан.

3. СХД-ийн I хорооны нутаг дэвсгэр дэх Баянголын хөндийг 2006 оны 06 сарын 20- ны 152 тоот тогтоолоор байгалийн цогцолбор газарт;

4. "Чингэлтэй хайрхан"-ыг Чингэлтэй дүүргийн ИТХ-ын 2006 оны 05 сарын 19-ний өдрийн 22 тоот тогтоолоор тус тус тусгай хамгаалалтанд авсан байна.

## *2.9 Нийгэмд эдийн засаг*

Хан-Уул Дүүрэг нь 16 хороонд хуваагддаг. 484.7 км² газар нутагтай. Монгол улсын томоохон үйлдвэр, цахилгаан станцууд оршдог.

**Хан-Уул дүүргийн газар нутаг**

Тус дүүрэг 48500 га нутаг дэвсгэртэй бөгөөд үүний 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67.6 хувь буюу 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11.3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт харьяалагддаг.

**Хан-Уул дүүргийн газар ашиглалт:**

Төсөл хэрэгжих орчин нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт, газар ашиглалтын ангиллаар хот, тосгон бусад суурины газарт хамаарагдана.




**Хан-Уул дүүргийн засаг захиргаа**

Хан-Уул дүүрэг нь засаг захиргааны бүтцийн хувьд төрийн удирдлагыг өөрөөудирдах ёсны удирдлагатай хослуулан барих хуулиар олгогдсон бүрэн эрх бүхий дүүргийн Засаг даргатай юм. Мөн анхан шатны нэгж болсон 16 хороотой, дүүргийн төр захиргааны 30 гаруй хэлтэс, албатай.

Дүүргийн хэмжээнд 2021 оны байдлаар 39189 өрхтэй, 141252 хүн амтай, 8000 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэр, компани, нөхөрлөл, хоршоотой. Одоогийн байдлаар 42686 толгой мал, 274887 тахиа, шувуу зэрэг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, дэд бүтэц, зам тээвэр хөгжсөн, Төрийн өмчийн 17 сургууль, 25 цэцэрлэг, 21 дээд болон их сургууль, коллежтэй, эрүүл мэнд, урлаг, соёл, спорт хөгжсөн дүүрэг юм.

**Эдийн засгийн хөгжил**

Нийт үйлдвэрлэлтийн 21 хувь, нийт борлуулалтын 20,7 хувийг цаашлаад Монгол Улсын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн 7.5 хувь, нийт борлуулалтын 9,2 хувийг үйлдвэрлэн борлуулж байна. Дүүргийн хэмжээгээр аж үйлдвэрийн жилийн дундаж үйлдвэрлэлт 272.8 тэрбум төгрөг, борлуулалт 286.7 тэрбум төгрөгт тус тус

хүрсэн байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний 38.8 хувийг ноос ноолуур, нэхмэл бүтээгдхүүн, 40.6 хувийг хүнсний бүтээгдхүүн, 14.6 хувийг цахилгаан эрчим хүч, 0.3 хувийг гутал хувцас, 0.8 хувийг барилгын материалын үйлдвэрлэл, 4.9 хувийг бусад үйлдвэрлэл эзэлдэг. Тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон компаниудаас дурьдвал “МИАТ” ХК, “АПУ” ХК, “ГОВЬ”ХК, “АТАР ӨРГӨӨ” ХК, “ТАВАН БОГД” ХК, “МОН-ФРЕШ” ХХК, “ЭРЭЛ” ХХК, “УЛААНБААТАР БАРИЛГА” ХК, КАШМЕРЕ ХОЛДИНГ, ВИТАВИТ ИНВЕСТ, ”УЛААНБААТАР ХИВС”ХК-ууд юм.

**Боловсрол, соёл шинжлэх ухаан**

Төрийн өмчийн 25 цэцэрлэг, Төрийн бус өмчийн 63 цэцэрлэгт нийтдээ 11705 гаруй хүүхдүүд суралцан 350 гаруй багш сурган хүмүүжүүлж байна. ЕБ-н Төрийн өмчийн 17 сургууль, Төрийн бус өмчийн 10 сургууль нийтдээ 22333 сурагч бага дунд суурь бүрэн дунд боловсролыг эзэмшиж байгаа бөгөөд 1500-аад багш ажиллаж байна. Дүүрэгт орших улсын, хувийн нийт 21 их дээд сургууль коллежид 19.800 оюутан суралцаж, 955 багш ажиллаж байна.

**Эрүүл мэнд**

Хан-Уул дүүрэгт ЭМН-1, Нэгдсэн эмнэлэг 1, өрхийн эмнэлэг 12, хувийн хэвшлийн эмнэлэг 18, ЭМН-ийн харьяа амбулатори 1, тосгоны хүн эмнэлэг 1, Сэргээн Засах Клиник Эмнэлэг, Оргил рашаан сувилал зэрэг эрүүл мэндийн 70 гаруй байгууллага иргэдэд нарийн мэргэжлийн болон суурь тусламж үйлчилгээг хүргэж байна.

# ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

*Хүснэгт 13. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа*

| Төслийн гол нөлөөлөл | Нөлөөлөлд өртөгч | Хамрах хүрээ | Сөрөг Нөлөөллийн эрчим | Үргэлжлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| Нэг. Төслийн үйл ажиллагааны явцад | | | | |
| Шатах тослох материал, ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал голын ус болон хөрсөнд шингэх | Гүний ус, газрын хөрс, ус, агаар | Төслийн талбай | Дунд | Төсөл хэрэгжих хугацаанд |
| Усны нөөц хомсдох | Гүний ус | Төслийн талбай (нөөц хомсдох) | Бага | Төсөл хэрэгжих хугацаанд |
| Зам, жим харгуй ихсэх | Агаар, хөрс, хүн, амьтан, ургамал | Авто зам түүний ойр орчим | Дунд | Төсөл хэрэгжих хугацаанд |

*Хүснэгт 14. Гол нөлөөллийн дүн шинжилгээ*

| Нөлөөллийн ангилал | Гол нөлөөлөл | Нөлөөллийн цар хүрээ | Нөлөөллийн эрчим | Нөлөөллийн үргэлжлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл<br>• Бохирдуулах<br><br>• Эвдэх | • Санамсаргүй алдаа гарсан тохиодолд автомашины тос алдаж хөрс, шороо бохирддог.<br>• Тээврийн машинууд зорчсоноос газрын хөрс элэгдэх хамаарагдаж байна. | Төслийн эдэлбэр газрын хэмжээ (10989 $м^2$) | Хөрс бохирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.<br><br>Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их | Төсөл хэрэгжих хугацаанд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| • Доройтуулах | • Төсөл орчмын хөрс элэгдэлд орох, дагтарших, ургамлын төрөл зүйл хомсдох зэрэг хамаарагдаж байна. | | хэмжээтэй байна.<br><br>Хөрс доройтуулах нөлөөллийн эрчим дунд зэрэг эрчимтэй байна. | |
| 2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл<br>• Бохирдуулах<br>• Нөөцийг бууруулах | Үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл нь ШТМ асгарах, бохирын шугам алдах зэрэг орно.<br><br>Газрын гүний ус ашигладаг учраас нөөцөд бага зэрэг нөлөөлнө. | | Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн эрчим их байна. | Төсөл хэрэгжих хугацаанд |
| 3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл<br>• Амьдрах орчинг хуваах<br>• Амьдрах орчинг доройтуулах<br>• Амьдрах орчинг хомсдуулах<br>• Нөөцийг бууруулах | Төслийн барилга байгууламжийг барих үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох<br><br>Үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлуулахгүй удаах зэргээс болж орчны | Төслийн эдэлбэр газрын хэмжээ (10989$м^2$) | Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна. | Төсөл хэрэгжих хугацаанд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох | | | |
| 4. Агаарт үзүүлэх нөлөөлөл<br>• Бохирдуулах<br>• Тоос | Ноолуур самнах цех нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг. | Төслийн эдэлбэр газрын хэмжээ (10989 $м^2$) | Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй байна. | Төсөл хэрэгжих хугацаанд |
| 5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс<br>• Хамгаалах<br>• Нүүлгэн шилжүүлэх | - | - | - | - |

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзвааc хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь үйлчлүүлэгчдийн хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холхиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

### *3.1 Төслийн барилга байгууламжийг өргөтгөн барьж байгуулах үеийн гол нөлөөлөл*

- Барилгын материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, барилгыг барих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Будаг, маажин, цавуу мэтийн химийн бодис асгарснаас хөрс ургамал, хөрсний ус, голын ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах

- Төслийн талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд орно.

### *3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл*

- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор голын эрэг бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, явган хүний жим зам тавих, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай. Барилга байгууламж барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, голын ус болон эрэг бохирдох, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

Эдгээр сөрөг нөлөөлөл нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй хандсанаас үүсч болно. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах бүлэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

### *3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл*

Төслийн явцад агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь автомашины утаа, санамсар болгоомжгүйгээс үүссэн химийн бодисын алдагдал үүнээс үүсэх хийн хагядал, тоосжилт байх боломжтой юм. Тоосжилтын эх үүсвэрүүд нь:

- Агуулахын засвар үйлчилгээ, тохижилтын ажлын үед
-Химийн бодис хадгалах агуулахын талбай дээрх машин механизмын хөдөлгөөн, дуу чимээ
-Химийн бодис тээвэрлэж буй машинаас асгарч болох шороо тоос

Төслийн талбайд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тухайн орон нутгийн тоосжилтийн түвшинг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болох бөгөөд агаарт дэгдэж буй тоосны улмаас үзэгдэх орчин багасаж осол, аваар гарч болзошгүй. Тоосжилтын улмаас төслийн ажилчид, ойр орчмын иргэдийн эрүүл мэнд болон эргэн тойрны байгаль орчинд зохих хэмжээгээр нөлөөлөх учир төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч буй

тоосжилтийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төсөл хэрэгжих орчин нь өнөөгийн байдлаар хүн, амьтан, ургамалд нөлөөлөхүйц агаарын ямар нэгэн бохирдолгүй байна.

**Хийн хаягдлаас үүсэх гол сөрөг нөлөөлөл**

Автомашины утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулна. 1кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин q=0.725, дизель q=0.825) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашины утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлоходоо бензин хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агууламжийг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агууламжийг үндсэн үзүүлэлт болгодог.

*Хүснэгт 15. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ*

| Бохирдол | Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед | Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш) | Машин тойргоор эргэх үед | Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош ) |
|---|---|---|---|---|
| CO (%) | 4 – 9 | < 1 – 8 | 1 – 7 | 2 – 9 |
| HC, $C_6H_{14}$ (ppm) | 500 – 1000 | 50 – 80 | 200 – 800 | 3000 – 12 000 |
| $NO_x$ (ppm) | 10 – 50 | 1000 - 4000 | 1000- 3000 | 5 – 50 |

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулав. Энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингийн хяналтын үзүүлэлт, ашиглагдах ач холбогдол юм.

*Хүснэгт 16. Автомашины утааны бүрдэл найрлага*

| № | Бүрдэл | Хөдөлгүүрийн төрөл | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | | Бензин | Дизель | |
| 1 | Азот (%) | 74-77 | 76-78 | **Хоргүй** |
| 2 | Хүчилтөрөгч %) | 0.3-8 | 2-18 | **Хоргүй** |
| 3 | Усны уур (%) | 3-5.5 | 0.5-4 | **Хоргүй** |
| 4 | Нүүрсхүчлийн хий (%) | 5-12 | 1-10 | **Хоргүй** |
| 5 | Нүүрстөрөгчийн исэл (%) | 1-10 | 0.01-0.5 | **Хортой** |
| 6 | Азотын исэл (%) | 0.1-0.5 | 0.001-0.4 | **Хортой** |
| 7 | Альдегид (%) | 0.0-0.2 | 0-0.009 | **Хортой** |
| 8 | Нүүрс-устөрөгчид (%) | 0.01-0.02 | 0.01-0.5 | **Хортой** |
| 9 | Хүхэрлэг хий (%) | 0-0.002 | 0-0.03 | **Хортой** |
| 10 | Хөө тортог (г/м$^3$) | 0-0.44 | 0.01-1.1 | **Хортой** |
| 11 | Бенз (а) пирен (г/м$^3$) | <0.00002 | <0.00001 | Хортой |

Хүснэгтээс харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн хэмжээ нь 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

### *3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл*

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлийн бага зэрэг эвдрэлтэй, Харин шороон замын хөрс машин техникийн нөлөөгөөр хүчтэй элэгдэл эвдрэлд орсноос хөрсний чулуужилт ихэссэн, зам дагуу тоосжилт ихтэйгээс ургамлан нөмрөг тоосжиж талхлагдсан зэрэг өөрчлөлттэй байна.

- **Төслийн өргөтгөл барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Барилга барих явцад барилгын суурь ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элсжилт үүсэх
- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр газрын гадарга, хэвлий бохирдох
- Болзошгүй тохиолдлоор гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

### *3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл*

Төслийн хашаан доторх хөрсний байгалийн элэгдэл эвдрэлийн үйл явц харилцан адилгүй хэлбэрээр тохиолдох ба хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс хүчтэй эвдрэлд орсон газар байхгүй. Харин шороон замын хөрс машин техникийн нөлөөгөөр хүчтэй элэгдэл эвдрэлд орсноос хөрсний чулуужилт ихэссэн, зам дагуу тоосжилт ихтэйгээс ургамлан нөмрөг тоосжиж талхлагдсан зэрэг өөрчлөлттэй байна.

Хөрс элэгдэж эвдрэх, бохирдох нөлөөлөл агуулахыг барьж байгуулах үед болон салаа зам гарах, хөрс хуулах, түрэх, овоолго хийх, хучилт хийх, суваг шуудуу далан, барилга байгууламжийн ажлын үед хөрс, гадаргын урсцад өөрчлөлт орж хөрсний эвдрэл үүсэх бөгөөд үүнд бас газрын гадаргын хэвгий, хөрсний шинж чанар, гадаргын урсац, ургамалжилт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлнө.

- Хөрс их хэмжээгээр эвдэрч, бүтэц шинж чанараа алдан ургамлан нөмрөгөө устгуулах ба улмаар хөрснөөс хийсэх шорооны хэмжээ ихсэж цөлжилтийн үйл явцыг түргэсгэх болно.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

**Төслийн өргөтгөл барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

**Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

### *3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл*

Ургамлан бүрхэвч нь мал болон зэрлэг амьтны тэжээл төдийгүй хөрсний дээд давхаргын дулаан ба чийгийг зохицуулагч, хөрс үүсгэгч, бэхжүүлэгч экосистемийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Ургамал нөмрөгийн талхагдал дунд зэрэг буй энэ орчимд хүн болоод техникийн нөлөөтэй талхагдалд нэлээд орсон байна.

Ургамлын нөмрөгт үзүүлэх шууд сөрөг нөлөөллийн хүчин зүйлүүд нь шороон зам, машин, хүний үйл ажиллагаанаас уг талбайнуудын ургамлын нөмрөг маш бага байна. Бүр мөсөн устах ургамлаас гаднах талбайн ургамлууд тоосжилт ба талхагдлаас шалтгаалж ургац бүтээмж доройтож, шарилж, лууль зэрэг хүмүүнсэг ургамал нэмэгдэх сөрөг нөлөөтэй. Үүнээс гадна барилгын ажлын явцад ургамлын нөмрөгийн болзошгүй хувьсал өөрчлөлт нь дараах хүчин зүйлээс шалтгаална. Үүнд:

- Хэт хуурайших, усан хангамж багасах, үер усны аюул нэмэгдсэнээс хөрсөн орчин өөрчлөгдөх хандлагатай болсон.

- Үйл ажиллагаа, автомашины замын тоос зэрэг нь ойр орчмын агаарыг тоосжуулахаас гадна, ургамлын навч бие эрхтэнд шороон тоос цугларч үйлдвэрийн болон түүний ойр хавийн ургамлын цаашдын амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ.

- Ургамлын ургац, үйл ажиллагаа явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй.

- Ургамлын бүрхэвч муудах устах зэргээс өвсөн тэжээлтэн амьтад устаж, тэдгээрийг барьж иддэг махчин амьтад ч дүрвэн зайлна.

**Төслийн үйл ажиллагаанаас ургамлан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,
- Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- Төсөл орчмын мод бут механик гэмтэлд өртөх

### *3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл*

Тус төслийн талбай нь амьтны аймгийн хувьд төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Төслийн барилга байгууламжийг барих үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны

амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох, дараа нь үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлуулахгүй удаах зэргээс болж орчны хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

**Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устах, хордох
- Төслийн барилгын ажлын үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### *3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл*

Усны хэрэглээ ба шингэн хаягдал: Ажилчдын ахуйн хэрэглээ болон цайны газраас хоногт хаягдах ахуйн бохир шингэн хаягдал гарна. Нэг хүний усны хэрэглээний нормыг 2015 оны 7 сарын 30 ны өдөр батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах норм” –ыг үндэслэн тооцов. Нийт ажилчид 5 хүн, ажиллах бөгөөд хоногт 1 ажилчин дунджаар 2.5 л ус ашиглахаар тооцов.

Нэг өдөрт: Нийт ажилтан 5 хүн*2.5л/хон=12,5 л сард буюу 30 хоногт 375 л, жилд буюу 264 хоногт 3,3 м3 ус ашиглахаар байна. Үүнээс 70% буюу 2.31м3/жилд шингэн хаягдал гарах тооцоотой байна.

Химийн бодис тээвэрлэхэд ашиглаж буй тээврийн хэрэгслээс алдагдах шатахуун, агуулахын үйл ажиллагаанаас ил задгай хог хаягдал гадаргын урсацаар зөөгдөн тархах болзошгүй гэвч энэ тохиолдол үүсэхгүй байх магадлалтай. Учир нь бодис, нэгдлүүд нь сав баглаа боодлын хувьд битүүмжлэл сайтай.

- Хавар цас хайлах, зун намар эрчимжил ихтэй хур бороо орох үед замыг хөндлөн огтолж буй сайр, судгуудад богино хугацаанд урсац үүсэж, үерлэж болзошгүй.
- Хур тунадас, ялангуяа эрчим ихтэй бороогоор сайр, судгууд үерлэн зам, ус зайлуулах байгууламжийг эвдлэх тохиолдол үүсэж болзошгүй.
- Агуулахын орц гарцын хаалга ус орохооргүй байхаар хийх, төлөвлөх.
- Замын ус өнгөрөөх гаргалгаа зэрэг нь салхи ба усны урсгалаар байнга зөөгдөх хагшаасаар дүүрч хур борооны болон уруйн үерийн үед бөглөрч зохиомол үер үүсгэж, зам болон ус өнгөрөөх байгууламжийг эвдэлж, сэтэлж, гуу жалга үүсгэн нурааж болзошгүй.

**Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар дамжуулан гол горхи бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын гол горхины ус ба түүний эргийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Түргэний голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдах

Сүүлийн жилүүдэд Түргэний голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдаж хавар, намрын улирлын урсацын хэмжээ багасах, үргэлжлэх хугацаа ихсэх, харин үерийн хэмжээ ихсэх, үргэлжлэх хугацаа багасах зэргээр өөрчлөгдөж, урсацын хуваарилалт орон зай ба цаг хугацааны хувьд алдагдсан байна. Ус ашиглалтын хэмжээ, хэрэгцээ нэмэгдэж, ашиглалтын горим нь голын горимтой зөрчилдөж байгаа шалтгаанаар улирлын чанартай хомсдол бий болдог байна.

### *3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл*

Тус төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн буюу үйлдвэрлэлийн хэсэгт байрладаг бөгөөд орон сууц олон нийтийн байгууламж бүхий хэсэг нь 1.0 км-ийн зайд үйлдвэрийн бүсэд байрладаг. Үйлдвэрийн байршлын хувьд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна.

Хан-Уул дүүргийн үйлдвэрийн хэсэгт Говь ХХК, үйлдвэрүүд байрладаг. Доорхи зурагт 1000 метр радиуст байрлах байгууламжийн зургийн харуулав.



*Зураг 10. Төслийн талбайн 1 км-ийн эргэн тойронд*

### 3.10 Хуримтлагдах нөлөөлөл

“ЛОРО ПЬЯНА МОНГОЛ” ХХК-ийн “Ноолуурын үйлдвэр төсөл” нь Хан-Уул дүүргийн 03-р хороонд хэрэгжиж байгаа бөгөөд тухайн бүс нутагт үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа явагддаг ба төслүүдийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол,

хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нөмрөг доройтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-г цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлагнах нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад баригдах барилга байгууламжийг барьж байгуулах, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа, орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

*Хүснэгт 17. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл*

| № | Хуримтлагдах нөлөөлөл | Нөлөөллийн шалтгаан | Хамрах цар хүрээ | Үргэлжлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Газрын гадарга ба хэвлий эвдрэлд өртөх | Бусад төслүүдийн нөлөөлөл | Төслийн талбай, нөлөөллийн бүс, | Өнгөрсөн, одоо, ирээдүй |
| 2 | Газрын доорх усны нөөц багасах | Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал | | Одоо, ирээдүй |
| 3 | Ургамалын нөмрөгийн доройтол | Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |
| 4 | Агаарын бохирдол нэмэгдэх | Хуурайшилт, бусад төслүүдийн ба хотын бохирдлын давхцал | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |
| 5 | Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх | Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.

# ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“ЛОРО ПЬЯНА МОНГОЛ” ХХК нь Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламжийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин  ажиллаж байна.

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв<br>Мян.төг | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан | Биелэлтийн үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2024 он | | | | |
| | | | Сар 07 | Сар 08 | Сар10 | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | “ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Ногоон байгууламж байгуулах | 5000.0 | захиалга | хүлээлцэх | | ХАБ-ын инженер | 50 ширхэг мод суулгасан<br><br> |
| | Нийт | 5000.0 | | | | | |

## ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“ЛОРО ПЬЯНА МОНГОЛ” ХХК-ийн Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламжийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

*Хүснэгт 18. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Байгаль орчны бүрдэл хэсгүүд | Болзошгүй сөрөг нөлөөллүүд | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (мян.төг) | Тоо хэмжээ | Нийт зардал (мян.төг) | Биелэлтийн үр дүн | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Агаар орчин** | Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс байгууллагын үйлчилгээний автомашины шатах тослох материалын ууршилт, утаа, тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу | Төслийн бохир ус цэвэршүүлэх байгууламжинд шүүлтүүр, агааржуулалтын винтелятор тавих<br>Самнах цехийн ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад агааржуулагч суурилуулах, агаар цэвэршүүлэгч суурилуулах, ажлын байрны дүгнэлт гаргуулах | Бохир ус цэвэршүүлэх байгууламж<br>Самнах цех | 2 | | 2 | 1000.0 | <br><br>Засвар шинэчлэлтийг ажлыг хийж агааржуулалтын хоолой болон төхөөрөмжүүдийг суулгасан. | Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 */ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –* |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | байснаас үнэрийн бохирдол үүсэж болно.<br><br>Ноолуур самнах цехийн ажлын байрны агаарын бохирдол хүний амьсгалын замын эрхтэнд нөлөөтэй байж болзошгүй. | | | | | | |   | *Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/* |
| 2 | **Усны нөөц, чанар** | Газрын доорх усыг авч ашигласанаар газрын доорх урсацын горим алдагдах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй. | Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах, тухай бүр нэн даруй засвар хийх | Ариун цэврийн байгууламж, гал тогоо | 1 | | | --*-- | Байнга хянаж байгаа болно. | Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586-98 (СХЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол.), Усан орчны чанарын хяналт шинжилгээ MNS4047-88 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал), Усны |
| | | | Бохирын хаягдал усны чанарыг тодорхойлуулж дүгнэлт гаргуулсаны дараа ашиглах | | 1 | | 1 | --*-- | Хавсралтаар шинжилгээг хавсаргав. | |
| | | | Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан | | | | | |   | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тодорхойлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | | | | | | | чанар, хаягдал бохир ус. MNS 4943-2014 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль *ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт – Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/* |
| | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Газар ашиглалтын байгуулсан гэрээний дагуу газрын төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах | | | | | --*-- | Хавсралтаар газрын тооцоо нийлсэн акт оруулаа. | |
| | | | Шатах тослох материал болон химийн бодис хадгалах ашиглах зааварчилгаа ны талаар ажилтан бүрийг сургалтанд хамруулах | | | | | --*-- | ХАБЭА сургалт явуулдаг. | |
| | **Нөлөөллийг бууруулах нийт зардал** | | | | | | | **1100.0** | | |

## ЗУРГАА.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал төг | Биелэлтийн үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | | “ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Төслийн талбайд нарс гацуур модоор тарих *(Тайлбар: “Улаанбаатар хотын 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц, суулгацын ААНБ-ын судалгаа” “Тоонот байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)* | Төслийн талбайд | ширхэг | 50 | 18000 | **5000.0** |  |
| | Нийт | | | | | | 5000.0 | |

## ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний нөлөөлийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

## НАЙМ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, төг | Биелэлтийн үр дүн | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | | 8 |
| 1. | Ажилчдын бие өвдөх, халдварт өвчин гарах | Ажилчдын эрүүл мэндийн үзлэг | Цехийн жилчид | 20 | 50.0 | 1000.0 | 2024 онд “Грандмед” эмнэлэгт үзлэгт хамруулж, хавсралтаар үзлэгийн нэгдсэн дүгнэлтийг оруулаа. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2018.06.27 нэмэлт |
| 2. | | Ажиллагсадыг хөдөлмөр хамгааллын хошуувч, хувцас хэрэгслээр хангах, тогтмол хоргүйжүүлэх нэмэлт бүтээгдэхүүнээр хангах | | 20 | 50 | 1000.0 |  | |
| | **Нийт** | | | | | **2000.0** | | |

| ЕС.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Хог хаягдлын ангилал** | **Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ** | **Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ** | **Нийт зардал, мян.төг** | **Биелэлтийн үр дүн** |
| | **1** | **2** | **3** | **7** | **8** |
| **1.** | **Ахуйн** | Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг засварлан сэргээж байх | **Хог хаягдлын цэг** | --*-- |  |
| **2.** | **Үйлдвэрийн** | Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулах, Байр сууц бүрт орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх | | |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **3.** | **Аюултай** | Химийн бодисны сав баглаа боодлыг устгуулах | **Агуулах** | **240.0** | **Цэцүүх трейд ХХК-тай гэрээтэй. Хавсаргав.** |
| | **Нийт** | | | **240.0** | |

## АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

| № | Хянах үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хяналтын давтамж | Шаардагдах зардал (урьдчилсан мян.төг) | Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|---|---|---|---|---|---|
| 1 | Агаарын чанар:<br><br>Агаарын тоосны (TSP, $PM_{10}$, $PM_{2.5}$) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх<br><br>Агаарын бохирдлын ($NO_2$, $SO_2$, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар. | Төслийн талбайн бохир цэвэрлэх байгууламж, самнах цех1,2 | Тоосны хяналт: Төслийн талбайд 2цэгт жилд 3 удаа /хавар, намар, зун/ 1 удаадаа Өдөрт 2 удаа<br><br>Агаарын найрлага: улиралд 1 удаа буюу жилд 3 удаа<br>Жил бүрийн 3,6,9 саруудад | Хавсралтаар оруулав. | MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,<br>MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,<br>MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга<br>MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,<br>MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга,<br>MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Усны хяналт шинжилгээ: Усны чанар: pH, уусcан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO3), Ca, Mg, Na, K, SO4, NO2, NO3, NH4, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол) | Бохир усны оролт, гаралт, унд ахуйн ус 3 цэгт | Жилд 1 удаа<br>Жил бүрийн 7сард | Хавсралтаар оруулав. | MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж<br>MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага<br>MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж<br>MNS 13.060.50 Усны чанарын стандарт<br>MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт |
| 3 | Хөрсний төлөв байдал, бохирдол:<br>Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент ($NO_3$, $P_2O_5$, $K_2O$), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр | Төслийн талбайн хог хаягдлын цэг сонгох | Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 1 удаа,<br><br>Жилд 1 удаа<br>Жил бүрийн 7сард | Хавсралтаар оруулав. | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,<br>MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,<br>MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,<br>MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга<br>MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага<br>MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга<br>MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга |
| Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тухайн жилийн нийт зардлын дүн | | | | 960.0 | |

## АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Биелэлтийн үр дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Газрын гэрчилгээ сунгуулах | 400.0 | Газрын гэрчилгээг сунгуулан хавсаргалаа | |
| | Нийт | 400.0 | | |

## АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | 2024 оны БОМТөлөвлөгөөг батлуулах | Цаасан | Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө | 2024.09 | - | ХАБ-ын инженер | БОАЖЯ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | 2024 оны батлагдсан БОМТөлөвлөгөөг танилцуулан ажлыг эхлүүлэх | Цаасан | Ажлын жагсаалт, хугацаа, зорилтууд | 2024.10 | - | ХАБ-ын инженер | Төслийн талбай |
| 3. | БОМТ-ны хэрэгжилтийн ажлын явцтай танилцах | Цаасан, зургаар | Хаягдал бохир усыг хөрсөнд үл нэвчих материалаар хийсэн байдал | 2024.11 | - | ХАБ-ын инженер | НБОГ |
| 4. | БОМТ-ний дагуу хийгдсэн ажлыг хүлээлгэн өгөх | Цаасан, зургаар | Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөө | 2022.11 | - | ХАБ-ын инженер | НБОГ |
| 5. | БОМТ-ны дагуу хийгдсэн ажлыг тайлагнах | Цаасан, зургаар | Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөө | 2022.12 | - | ХАБ-ын инженер | НБОГ, БОАЖЯ |
| | Нийт | | | | - | | |

**Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 5600 мян.төг**

**УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР**
**УСНЫ ТӨВ ЛАБОРАТОРИ**
*WATER SUPPLY & SEWERAGE AUTHORITY*
*CENTRAL WATER LABORATORY*

*Улаанбаатар 13340; Баянзүрх дүүрэг; 4-р хороо; Б.Доржийн гудамж*
*Утас: +976 70157034; www.usug.ub.gov.mn*


# СОРИЛТЫН ТАЙЛАН
## TEST REPORT

**Сорилтын тайлангийн дугаар** */Report No/* 24/1684
**Хүсэлт гаргагчийн нэр** */Client/* Лоро Пьяна Монгол ХХК
**Сорьц авсан хүний нэр; албан тушаал** */Sampled by/* Т.Нэмэхбаяр, сорьц авагч
**Холбоо барих мэдээлэл** */Contact information/* Мөнх-Эрдэнэ,99799364
**Дэд лабораторийн нэр**/*Sub laboratory name/* Хими

| | | | |
|---|---|---|---|
| **Ерөнхий шаардлага** *General requirements* | MNS 6561:2015 | **Сорьц авсан огноо** *Sampled date* | 2024/07/23 |
| **Сорьцын тодорхойлолт** *Sample description* | Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус *Industrial effluent to main sewerage system* | **Хүлээн авсан огноо** *Received date* | 2024/07/23 |
| **Сорьц авсан аргачлал** *Sampling method* | MNS ISO 5667-10:2001 | **Шинжилсэн огноо** *Analysed date* | 2024/07/23-2024/07/25 |

| Д/д | Сорьцын код *Sample ID* | Сорьц авсан газар *Sample location/source* | Сорьц авсан цэг *Sample point* | Хэмжээ *Sample quantity* |
|---|---|---|---|---|
| 1 | Б241010 | ХУД, Ноос, ноолуур угаах болон боловсруулах үйлдвэр | цэвэрлэх байгууламж | 0л |

| Д/д | Шинжилгээний аргачлал *Standard method* | Шинжилсэн үзүүлэлт *Parameters* | Хэмжих нэгж *Unit* | ЗДА *PL* | Б241010 |
|---|---|---|---|---|---|
| **Химийн шинжилгээний үр дүн** */Chemical result/* | | | | | |
| 1 | MNS ISO 10523:2001 | Усны орчин pH / *pH value/* | | 6-9 | 7.49 |
| 2 | MNS ISO 11923:2001 | Умбуур бодис / *Suspended solids/* | мг/л ;*mg/L* | 400 | 2 |
| 3 | MNS ISO 6060:2001 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч / *Chemical oxygen demand; COD-Cr/* | мг/л ;*mg/L* | 800 | 117.1 |
| 4 | MNS 5597:2006 | Сульфид / *Sulfide/* | мг/л ;*mg/L* | 5 | 0.001 |

ЗДА-Зөвшөөрөгдөх дээд агуулга /PL-Permissible limit/

***End of Report***

Хянасан */Verified by/*

Цэнд-Аюушийн Болормаа
Химич-чанарын менежер
*Chemical quality manager*

Баталсан */Approved by/*

Нямдагвын Цэвэг-Очир
Дарга
*Head of laboratory*

# ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

**Хянан баталгааны төрөл:** Захиалгат хянан баталгаа **Огноо:** 2022-05-18

1. **Газар ашиглагч:** Лоро Пьяна Монгол ХХК
2. **Аймаг (нийслэл):** Улаанбаатар **Сум (дүүрэг):** Хан-Уул
3. **Байршил, хаяг:** ҮЙлдвэр-1/17060/, Үйлдвэрийн
4. **Нэгж талбарын дугаар:** 1780300133
5. **Хөрсний нэр:**
6. **Ургамалжилт:**
7. **Нийт талбайн хэмжээ:** 10861 м$^2$
8. **Газар эзэмших зориулалт:** Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор
9. **Одоогийн газар ашиглалтын хэлбэр:** Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор
10. **Газар ашиглах, эзэмших шийдвэр***:* Улаанбаатар аймаг /нийслэл/-ийн Хан-Уул сум/дүүргийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 01122-А/916/2014 тоот захирамж
11. **Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар***:*
12. **Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт**

Нийт эзэмшил талбай 10864 Нэгж талбарын талбай 10864 А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай 10864 1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай 4853 үүнээс Сул чөлөөтэй талбай 2618 Ногоон байгууламж 1999 1.Үйл ажиллагаанд өртсөн талбай 6011 үүнээс Барилга 5277 Бетон талбай 734

Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

| Газар ашиглалтын байдал | Талбай | Эвдэрч бохирдсон талбай | | |
|---|---|---|---|---|
| | | Физикийн | Химийн | Биологийн |
| Нийт эзэмшил газар | 10864 | - | - | - |
| Нэгж талбарын талбай | 10864 | - | - | - |
| Газар дээрээ ашиглаж байгаа талбай | - | - | - | - |
| Дутуу ашиглаж байгаа газар | - | - | - | - |
| Илүү ашиглаж байгаа газар | - | - | - | - |
| **А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай** | | | | |
| **1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай** | | | | |
| Сул чөлөөтэй талбай | 2618 | - | - | - |
| ногоон байгууламж | 1999 | - | - | - |
| **2.Үйл ажиллагаанд өртсөн талбай** | | | | |
| Барилга | 5277 | + | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Цементэн талбай | 734 | + | - | - |
| **Б.Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай** | | | | |
| **1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай** | | | | |
| **2.Үйл ажиллагаанд өртсөн талбай** | | | | |

## 13. Газар ашиглалтын онцлог, гадаргын төлөв байдал

Газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт бага зэрэг элэгдэл, эвдрэлд өртсөн ба гадаргын төрх байдлын хувьд тэгш. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй .

## 14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл

Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдээс авч үзвэл А үе давхаргад урвалын орчин сул хүчиллэг, ялзмаг бага зэрэг, хөдөлгөөнт элементүүд хөрсний хангамжийн зэргээр авч үзвэл нитрат илэрсэн, фосфор ,кали бага. Харин давсжилтгүй,солилцох сууриудад кальцийн хэмжээ дунд байгаа бөгөөд доод үе давхаргад карбонатгүй, хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнийг дээрх хүснэгтээр харуулав.Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд өнгөн үе давхаргад том ширхэгтэй элсний агууламж их буюу физик элсний эзлэх хувь 48.7% байна. Харин А үе давхаргад физик шаврын эзлэх хувь 13.5% байгаа нь тухайн хөрс холбоот элсэн механик бүрэлдэхүүнтэйг илтгэж байна.Хөрсний хүнд металлын агууламжийн хувьд кадми илрээгүй цайрын хувьд өмнөх хянан баталгааны шинжилгээнээс өссөн үзүүлэлттэй гарсан тул анхаарах, бусад элементүүд “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5850:2019 стандартад заасан хэмжээнээс хэтрээгүй байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

| Цэгийн дугаар | Давхарга | Гүн см | Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | 0.001-с бага | 0.01-с бага |
| 1780300133001001 | A | 0-20 | 21.4 | 48.7 | 16.5 | 0.4 | 8.0 | 5.1 | 13.5 |

Хөрсний агрохимийн шинж чанар

| Цэгийн дугаар | Давхарга | Гүн см | Ялзмаг, % | pH | ЦДЧ, dsm | Давс, % | CaCo3, % | Солилцох суурь, мг-экв/100гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ca | Mg | K2O | p2o5 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1780300133001001 | A | 0-20 | 1.88 | 8.0 | 0.123 | 0.06 | 1.52 | 13.6 | 5.5 | 18 | 1.9 |

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

| Цэгийн дугаар | Давхарга | Нянгийн тоо | Гэдэсний савханцарын таньц | Перфингенсийн таньц |
|---|---|---|---|---|
| 1780300133001001 | Өгөгдөл хоосон байна | | | |

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж /үндсэн/

| Цэгийн дугаар | Давхарга | Хүнд металлын агууламж, мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Pb /Хар тугалга/ | Cd /Кадьми/ | Zn /Цайр/ | Cu /Зэс/ | Ni /Никель/ | Cr /Хром/ |
| 1780300133001001 | A | 34.5 | | 242.0 | 44.8 | 31.7 | 8.41 |

**15. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтолын зэрэглэл**

Тус судалгааны талбай нь үетэн-алаг өвс, ишгүй гичгэнэ, хиаг, агь зэрэг олон зүйлийн ургамлан бүлгэмдэлтэй. Ургамлан нөмрөгийн 85% нь талхлагдсан, бүрхэц сийрэг, нэгж талбарын зүүн хэсгээр ургамлан нөмрөг өөрчлөгдөж хог ургамлаар солигдсон ба баруун хэсгээр гацуур, нарс, хайлаас, шинс зэргийг тариж ургуулсан байна. 16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй

**16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал:**

Газрын ашиглалтын тус нэгж талбай нь орц гарц хаагаагүй ба зорчих хэсэгт саад учруулахгүй. Газрын гадаргын төрх байдлын хувьд бүрэн өөрчлөгдсөн байна. Үйлдвэрийн хашаан доторх авто машин зогсоол, зам талбай зохион байгуулалт сайтай. Газрын тухай хуулийн 56-р зүйлийн 56.6 дах заалт / Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх/. Талбайн зүүн болон хойд хэсгүүдийг сайтар анхаарах. Үйлдвэрийн зүүн талын хог хаягдалын цэгийн ойр орчмыг сайтар цэвэрлэх, газрын гадарга хөрс боридохоос сэргийлж цемэнтлэх шаардлагатай. Цаашид үйл ажиллагаа эрчимжих нөхцөлд хүнд металлын агууламжийг хянаж байх.

**17. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, зөвлөмж**

“Лоро Пъяна Монгол” ХХК-ний газрын төлөв байдалд чанарын өөрчлөлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний тухай зөвлөмжлөх: Тус нэгж талбайд үйл ажиллагаа явуулахдаа хүрээлэн буй байгаль орчинд хор хохирол багатайгаар хөрс ургамлан нөмрөгийг нэмж доройтуулахгүйгээр ашиглаж, эвдэрч доройтсон газарт хугацаа алдалгүйгээр нөхөн сэргээлтийн ажлыг хийх. Мөн нэгж талбайн зүүн урд талаас орох зам талбайг тохижуулах шаардлагатай. Сул чөлөөтэй байгаа хэсэгт ургамалжуулах, тухайн хөрсөнд тохирсон мод, модлог ургамлыг тарьж байх нь зүйтэй. Газрын тухай хуулийн 56-

р зүйлийн 56.6-дахь заалт/ Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана/-ыг анхаарах шаалдлагтай. ГЧБЧУХБ-ны ажлын үр дүнд үндэслэн зөвлөсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. ДҮГНЭЛТ ГАРГАСАН: Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мэргэжлийн байгууллага “Мандал ногоон тал” ХХК

**БАТАЛГААЖСАН.**

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,

ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР //

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ЛОРО ПЪЯНА МОНГОЛ" ХХК ЗАХИРАЛ — А.БУЯНДЭЛГЭР

# "ЛОРО ПЪЯНА МОНГОЛ" ХХК НИЙ УЛААНБААТАР, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ.НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2046237

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН — ПҮРЭВ. ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
"ЛОРО ПЪЯНА МОНГОЛ" ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН — СОДХҮҮ

2024 ОН

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006.08.29
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9019011059
/Улсын бүртгэлийн дугаар/

2046237
/Регистрийн дугаар/

Лоропьяна монгол ХХК - Гадаадын хөрөнгө оруулалттай
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

| | | |
|---|---|---|
| Тушаал | А-132 | 1997.03.17 |
| /шийдвэрийн нэр/ | /дугаар/ | он, сар, өдөр |

| | |
|---|---|
| 171100 | Ноолуур боловсруулах |
| /код/ | /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/ |
| 173000 | Сүлжмэл эдлэл үйлдвэрлэх |
| 511000 | Гадаад худалдаа |

/код/ /Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

| | | |
|---|---|---|
| 1 | 1 | 1,641,469.8 |
| хугацаа | /гишүүдийн тоо/ | /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/ |

Хан-Уул, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Өөрийн байр - 00, утас1:343533, утас2:343529, факс:976-343533
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ҮНДЭСНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЛБА УХА0175

Улсын бүртгэлийн алба
/бүртгэсэн байгууллагын нэр/

## Харилцах банкны бүртгэл:

| Харилцах банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан, тэмдэг |
|---|---|---|---|
| Худалдаа хөгжлийн банк | Төгрөгийн | 4060.../499023869 | Ц.Билгүүн / Ц.Цэдэндорж |
| Худалдаа хөгжлийн банк | Валютын | 499036175 | Ц.Цэдэндорж |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

| Д/д | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга | Огноо | Бүртгэсэн ажилтан, тэмдэг |
|---|---|---|---|
| 1 | Хөдөө аж ахуйн банк 5003008251 тоот төгрөгийн дансыг бүртгэв. | 2006.12.20 | Ц.Цэдэндорж |
| 1 | Хөдөө аж ахуйн банк 5003271449 тоот валютын дансыг бүртгэв. | 2006.12.20 | Ц.Цэдэндорж |
| 2 | Татвар төлөгчийн тооллогод хамрагдав | 2007.04.27 | М.Оюунчимэг |
| 3 | 1 жилийн хугацаагаар үйл ажиллагаа эрхлэхийг бүртгэв. | 2007.08.28 | Г.Мягмар |
| 4 | 1 жилийн хугацаагаар үйл ажиллагаа эрхлэхийг бүртгэв. | 2009.01.12 | Ц.Цэдэндорж |
| 5 | Дүрмийн сан 1092933-р нэмэгдэж 2734402.8.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2009.01.12 | Ц.Цэдэндорж |
| 6 | Дүрмийн сан 0-р хасагдаж 2734402.8.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2009.02.04 | Ц.Цэдэндорж |
| 7 | 1 жилийн хугацаагаар үйл ажиллагаа эрхлэхийг бүртгэв. | 2010.01.08 | Ч.Батцэцэг |
| 8 | **Дүрмийн сан 0-р хасагдаж 2734402.8.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.** | 2010.11.29 | Б.Ариунболд |
| 9 | 1 жилийн хугацаагаар үйл ажиллагаа эрхлэхийг бүртгэв. | 2010.11.29 | Б.Ариунболд |
| 10 | Ажиллах хугацааг 2012.08.01-ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2011.11.28 | М.Баяржаргалант |
| 11 | Хувь нийлүүлэгч 0-ээр нэмэгдэж, 1-ээр хасагдан үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2012.01.18 | Ш.Цэнгэл |
| 12 | Ажиллах хугацааг 2013.08.01-ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2012.07.23 | Д.Чулуунтуяа |
| 11 | Ажиллах хугацааг 2013.09.03 -ний өдрөөс 2014.08.01 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2013.09.03 | Д.Аюурзана |
| 12 | Ажиллах хугацааг 2014.08.01 -ний өдрөөс 2015.08.01 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2014.08.07 | Т.Энхбаяр |
| 13 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 5972360.9 мян.төг-р нэмэгдэж нийт 8706763.7 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2014.10.13 | С.Ундрах |
| 14 | Ажиллах хугацааг 2015.08.01 -ний өдрөөс 2017.08.01 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2015.08.07 | Н.Цэжидбүлэм |
| 15 | Ажиллах хугацааг 2017.08.30 -ний өдрөөс 2019.08.01 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2017.08.30 | Х.Түвшинтөр |
| 16 | Ажиллах хугацааг 2019.08.01 -ний өдрөөс 2021.08.01 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2019.08.06 | Г.Алтай |
| 17 | Эцсийн өмчлөгч бүртгэв. | 2020.12.30 | У.Мандахтуяа |
| 18 | Үйл ажиллагаа эрхлэх хугацааг хугацаагүй болгов. | 2021.09.14 | Э.Эрдэнэбилэг |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР АШИГЛАХ ЭРХИЙН

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар: 0000165857**

Итали улсын харъяат Лоро Пьяна Монгол ХХК 2046237
(нэр) (регистр)

Нийслэлийн Засаг даргын захирамж 20 22 оны 12 сарын 21 өдрийн А/1589 тоот
(шийдвэр гаргагч)

шийдвэрийг үндэслэн Улаанбаатар Хан-Уул 3-р хороо
(аймаг, нийслэл) (сум, дүүрэг) (баг, хороо)

Үйлдвэр, Үйлдвэрийн 41 хаягт
(гудамжны нэр) (хашааны дугаар)

байрлах, нэгж талбарын 1780300133 дугаар бүхий 10980 м.кв газрыг

Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалтаар

5 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн А-2206009420

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

**Хэвлэсэн огноо: 2023-02-14**

# Нийслэлийн газар зохион байгуулалтын алба

Нэгж талбарын дугаар: 1780300133 Эрхийн төрөл: ашиглах

Регистрийн дугаар: 2046237 Хуулийн этгээдийн нэр: Лоро Пьяна Монгол ХХК

| | | | | |
|---|---|---|---|---|
| **ХАЯГ:** | Аймаг/Хот: Улаанбаатар | Сум/Дүүрэг: Хан-Уул | Баг/Хороо: 3-р хороо | Кадастрын муж: 7803 |
| | ШИНЭ: Гудамж: ҮЙлдвэр, Үйлдвэрийн Тоот: 41 | | ХУУЧИН: ГудамжҮЙлдвэр, Үйлдвэрийн Тоот: 41 | |




Орчны тойм



Масштаб = 1: 27084

Координатын систем:

WGS84/UTM 48N

EPSG: 32648

Талбайн хэмжээ: 10980 квадрат метр

Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

www.egazar.gov.mn

Зургийн масштаб = 1:1029 (1 сантиметрт 10.29 метр багтана) Хэвлэсэн огноо: 2023-02-14

Нэгж талбарын дугаар: 1780300133

**ХАЯГ:** Аймаг/Хот: Улаанбаатар Сум/Дүүрэг: Хан-Уул Баг/Хороо: 3-р хороо Кадастрын муж: 7803
Гудамж: ҮЙлдвэр, Үйлдвэрийн Тоот: 41

Нэгж талбар

| № | X | Y | Урт |
|---|---|---|---|
| 1 | 640499.02 | 5306858.35 | 36.28 |
| 2 | 640529.52 | 5306878.06 | 7.43 |
| 3 | 640534.20 | 5306872.30 | 14.44 |
| 4 | 640541.48 | 5306859.84 | 13.21 |
| 5 | 640552.74 | 5306866.79 | 22.65 |
| 6 | 640564.02 | 5306847.17 | 72.58 |
| 7 | 640626.06 | 5306884.95 | 36.96 |
| 8 | 640606.92 | 5306916.54 | 21.91 |
| 9 | 640625.76 | 5306927.77 | 0.12 |
| 10 | 640625.69 | 5306927.87 | 12.42 |
| 11 | 640636.34 | 5306934.29 | 9.54 |
| 12 | 640644.75 | 5306938.81 | 109.26 |
| 13 | 640700.40 | 5306844.86 | 30.27 |
| 14 | 640674.81 | 5306828.64 | 12.40 |
| 15 | 640664.03 | 5306822.48 | 6.11 |
| 16 | 640660.81 | 5306827.68 | 7.03 |
| 17 | 640657.12 | 5306833.66 | 23.91 |
| 18 | 640644.75 | 5306854.11 | 5.96 |
| 19 | 640639.64 | 5306851.03 | 12.94 |
| 20 | 640646.32 | 5306839.95 | 76.03 |
| 21 | 640580.50 | 5306801.73 | 5.88 |
| 22 | 640575.34 | 5306798.91 | 1.57 |
| 23 | 640573.96 | 5306798.16 | 96.08 |

Барилга

| № | X | Y | Урт | Дугаар | Талбай |
|---|---|---|---|---|---|
| 41.1 | 640573.64 | 5306844.25 | 65.21 | 41 | 1070 |
| 41.2 | 640629.51 | 5306878.02 | 15.22 | | |
| 41.3 | 640637.38 | 5306865.00 | 72.19 | | |
| 41.4 | 640575.53 | 5306827.62 | 11.00 | | |
| 41.5 | 640569.90 | 5306837.06 | 6.86 | | |
| 41.6 | 640575.77 | 5306840.60 | 4.23 | | |
| Б:70.1 | 640679.71 | 5306865.78 | 22.69 | Б:70 | 320 |
| Б:70.2 | 640689.56 | 5306845.35 | 12.74 | | |
| Б:70.3 | 640677.89 | 5306840.20 | 6.66 | | |
| Б:70.4 | 640671.76 | 5306837.61 | 2.47 | | |
| Б:70.5 | 640670.83 | 5306839.90 | 6.59 | | |
| Б:70.6 | 640676.87 | 5306842.55 | 14.79 | | |
| Б:70.7 | 640670.74 | 5306856.00 | 8.29 | | |
| Б:70.8 | 640663.16 | 5306852.63 | 2.62 | | |
| Б:70.9 | 640662.11 | 5306855.03 | 8.25 | | |
| Б:70.10 | 640669.68 | 5306858.34 | 2.68 | | |
| Б:70.11 | 640668.57 | 5306860.77 | 12.19 | | |

БАТЛАВ.
"ДЦС-3" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.......................... Ч.ЧИНБАТ

БАТЛАВ.
"ЛОРО ПЪЯНА МОНГОЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.......................... А.БУЯНДЭЛГЭР

**УУРЫН ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ, ХЭРЭГЛЭХ ГЭРЭЭ**

2021 оны 03 сарын 02 өдөр №3-3-30/21 Улаанбаатар хот

Нэг талаас **"ДЦС-3" ТӨХК** /цаашид "Хангагч" гэх /-ийг төлөөлж **Санхүү эрхэлсэн дэд захирал Т.Энхтөр**, нөгөө талаас **"ЛОРО ПЪЯНА МОНГОЛ" ХХК**-ийн /цаашид "Хэрэглэгч" гэх/ **Техник удирдлагын хэлтсийн дарга ажилтай Д.Батнасан /РД:ЧД67122679/** нар Монгол Улсын иргэний Хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч - Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд харилцан тохиролцож, хангагч нь стандартын шаардлага хангасан уураар хангах, хэрэглэгч нь хэрэглэсэн уурын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэг хүлээж энэхүү гэрээг байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн харилцааг зохицуулах, гэрээний нөхцөл, тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, эрчим хүчний чанар, тоо хэмжээ, төлбөр тооцооны нөхцөл, хангагч хэрэглэгчийн эрх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэхэд гэрээний зорилго оршино.
1.2. Талууд Монгол улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос тогтоосон үнэ тариф, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч - Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм зэргийг үндэслэн гэрээ байгуулав.
1.3. Хэрэглэгч нь зохих журмын дагуу техникийн нөхцөл авсан, эрчим хүчээр хангах гэрээний нөхцлийг харилцан тохиролцож зөвшөөрсөн, урьд нь хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй, барьцаа төлбөр байршуулсан байна. Барьцаа төлбөрийг гэрээ цуцалсны дараа эргүүлж олгоно. Хэрэглэгч нь төлбөрөө 2-оос дээш сараар төлөөгүй, удаан хугацаагаар зогссон тохиолдолд барьцаа төлбөрөөс уурын төлбөрт шилжүүлэн суутгаж болно.
1.4. Энэхүү гэрээгээр хэрэглэгч нь **2021 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн 2021 оны 12 дугаар сарын 31- нийг дуусталх** хугацаанд эрчим хүчээр хангагдана.
1.5. Энэхүү гэрээ нь дараагийн гэрээ хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

## Хоёр. Хангагчийн эрх, үүрэг

2.1. Хангагч нь Монгол Улсын иргэний Хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч -Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм, хангагч хэрэглэгчийн хоорондын аж ахуйн гэрээ болон бусад хууль, тогтоомж, дүрэм журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. Хангагч нь эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, газар эзэмших гэрчилгээ зэргийг үндэслэн уурын дулааны эрчим хүчээр хангах гэрээг байгуулах үүрэгтэй.
2.3. Хангагч нь чанар, стандартын шаардлага хангасан уурын дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах үүрэгтэй.
2.4. Дулаан түгээх алдагдлыг бууруулах арга хэмжээг тогтмол авах, алдагдлыг бууруулах тооцоо, судалгаа, төлөвлөгөө, төсөвтэй байх.
2.5. Хангагч нь хэрэглэгчийн баталгаажсан тоолуур хэмжих хэрэгслийн заалтыг үндэслэн уурын дулааны эрчим хүчний хэрэглээг тооцож, төлбөрийн нэхэмжлэхийг өгч, төлбөрийг авах үүрэг хүлээнэ.
2.6. Дулааны сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм, нормативын дагуу чанартай хийх, хэрэглэгчдэд мөн адил шаардлага, хяналт тавих үүрэгтэй.
2.7. Хангагч нь Хэрэглэгчийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийн ашиглалт, ААД-ийн хэрэгжилт, уурын дулааны эрчим хүчний төлбөрийн төлөлт, тоолуур хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг шалгах зорилгоор барилга байгууламжид нь нэвтрэн орох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай шаардлага, акт тавих, мэдэгдэл өгөх эрхтэй.
2.8. Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Хангагч нь Эрчим хүчний тухай хууль болон энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу хэрэглэгчийн эрчим хүчний хангамжийг түдгэлзүүлж, зөрчлийг арилгахыг шаардах эрхтэй. Зөрчил арилсан тухай бүр хэрэглэгчийг эрчим хүчээр саадгүй хангах бөгөөд хэрэглэгчийн буруугаас таслах, залгахад гарсан зардлыг хэрэглэгч хариуцна.
2.9. Шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах эрхтэй.
2.10. Хангагч нь хэрэглэгчийн хэмжих хэрэгслийн техникийн бэлэн байдал, хэмжих хэрэгслийн туршилт тохируулга, шалгалт, баталгаажуулалтыг хугацаанд нь бүрэн хийлгэж, түүнд хяналт тавьж, зөрчлийг арилгуулан хэмжүүрийн үнэн зөв байдлыг хангуулах үүрэгтэй.
2.11. Байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд эрчим хүчний төлөвлөгөөт таслалт (урсгал засвар, өдөр тутмын гэмтэл, саатал)-ын улмаас гэрээнд заасан эрчим хүчээр хангахгүй болсон тухайгаа хэрэглэгчид 4-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ. Станцын бүрэн зогсолтын үед хийгдэх их засварын ажлыг гүйцэтгэхдээ хэрэглэгчдэд 7 хоногийн өмнө албан мэдэгдэл өгөх үүрэгтэй.
2.12. Хэрэглэгчээс техникийн нөхцлөө сунгуулах, шинэчлэн гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж хариуг өгнө.
2.13. Хангагч нь хүндэтгэн үзэх шатгаангүйгээр уурын дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулахаас татгалзах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах эрхгүй.
2.14. Хангагч нь эрчим хүчний үнэ, тарифт орох өөрчлөлтийг тухай бүрт нь хэрэглэгчид мэдэгдэх үүрэгтэй.

## Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

3.1. Эрчим хүч хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэмжлийн нэдмэл байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч -Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм, хангагч хэрэглэгчийн хоорондын аж ахуйн гэрээ болон бусад хууль, тогтоомж, дүрэм журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
3.2. Хэрэглэгч нь аж ахуйн гэрээ байгуулахын тулд өөрийн хөрөнгөөр тоолуур хэмжих хэрэгслийг суурьлуулж, өөрийн эзэмшлийн шугам тоноглол, хэмжих хэрэгсэлд шахалт, шалгалт, туршилт, угаалга хийсэн баримтын бүрдлийг хангасан байхын зэрэгцээ технологийн уур хэрэглэх угсралтын схем, агаар гаргагч, юүлэгчийн угсралтын зургийг төслийн дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн зургийг хавсаргахын хамт хоногийн, цагийн ачааллын график, нийт хэрэгцээг тодорхойлсон тооцоог хавсаргана.
3.3. Хэрэглэгч нь эрчим хүчний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх үүрэгтэй.

3.4. Хэрэглэгч нь нэр, хаяг, байршил, харилцах банк, дансны дугаар өөрчлөгдвөл энэ тухайгаа ажлын 1 хоногийн дотор хангагчид мэдэгдэх ба бусдад шилжүүлсэн бол 7 хоногийн дотор төлбөр тооцоог хийж дуусгах үүрэгтэй.

3.5. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, хэмжүүрийн ашиглалт, найдвартай ажиллагааг хангах үүднээс үзлэг үйлчилгээ, суурилуулах, баталгаажуулах, шалгуулах, хэмжүүрийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, засвар үйлчилгээг өөрийн хөрөнгөөр, мэргэжлийн байгууллага, ажилтнаар хийлгэнэ.

3.6. Хэрэглэгч нь авч буй уурыг алдагдалгүй үр ашигтай хэрэглэх үүрэгтэй бөгөөд гарсан алдагдлыг нөхөж төлнө.

3.7. Эрчим хүчээр хангагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр уурын дулааны эрчим хүчний хангамжийг тасалдуулсан, гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлт бүхий эрчим хүчээр хангаагүй бол нийлүүлээгүй буюу дутуу нийлүүлсэн эрчим хүчний үнийн дүнгийн 5 хүртэл хувьтай тэнцэх торгууль төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй.

3.8. Хэрэглэгч нь илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор хангагчаас тавьсан акт, шаардлага, мэдэгдлийн заалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.9. Энэ гэрээний 5.1, 5,2-д зааснаас бусад үндэслэлээр эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлснээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

3.10. Хангагчтай тооцоо хийдэг тоолуур хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ажиллагааны байдалд өдөр бүр хяналт тавьж ашиглалтыг бүрэн хариуцаж гэмтэл гарсан болон гарч болзошгүй тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэнэ.

/Эрчим хүчний хангамжтай холбоотой асуудлаар-**343097/**

3.11. Эрчим хүчний улсын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтны тавьсан лац, ломбо, бусад битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.

3.12. Хэрэглэгч өөрийн хүсэлтээр уур нээлгэх, хаалгах тохиолдолд 3 хоногийн өмнө албан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.13. Хэрэглэгч нь өргөтгөл шинэчлэл хийх, барилга байгууламжид дулааны эрчим хүч авах, ачааллыг өөрчлөх болон дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, халаалтын системийн техникийн шийдлийг өөрчлөх, технологийн шинэчлэл хийх тохиолдол бүрт хангагчаас техникийн нөхцөл шинээр авна.

3.14. Байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд гэрээнд заасан эрчим хүчийг авахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа хангагчид 7 хоногийн өмнө мэдэгдэнэ.

3.15. Үл хөдлөх хөрөнгө эзэмшигч нь өөрийн эзэмшлийн газар, байшин барилгаа бусдад түрээслэх, эзэмшүүлэх, худалдахдаа хэрэглэсэн эрчим хүчний тооцоогоо хийж, гэрээг дуусгавар болгосон байна. Хэрвээ гэрээ дуусгавар болгоогүй нөхцөлд үүссэн төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдлийг гэрээ хийсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцан барагдуулах үүрэгтэй. Шилжиж явсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийн үлдэгдлийг төлж дуустал шинээр шилжиж ирсэн хэрэглэгчтэй гэрээ хийхгүй байх эрхийг хангагч эдлэнэ.

3.16. Хангагчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах эрхтэй.

3.17. Уурын шугам хоолой, тоног төхөөрөмж, шугам сүлжээний ашиглалт, засварыг хариуцах мэргэжлийн ажилтанг томилж ажиллуулах, тэдгээрийн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэх. Дулааны тоног төхөөрөмжийн ашиглалт, засварыг мэргэжлийн бус хүнд хариуцуулахыг хориглоно.

3.18. Хэрэглэгч нь уурын тоолуур хэмжих хэрэгсэл суурилагдсан орчныг эмх цэгцтэй, цэвэр, байнгын гэрэлтүүлэг, дулаацуулга, агааржуулалттай, засвар үйлчилгээ хийх боломжтой зориулалтын узель /тусгаарлах өрөө/-ээр хангана. Узелийг орон байр, агуулах болон бусад зориулалтаар ашиглахгүй байна.

3.19. Хэрэглэгч нь уурын тоолуур, хэмжих хэрэгслийн цахилгааны тэжээлийг найдвартай эх үүсвэрээс холбож, хүчдэл давтамжийн хэлбэлзлээс хамгаалах төхөөрөмжөөр тоноглосон байна.

3.20. Хэрэглэгч нь технологийн уур хэрэглээгүй үедээ тоолуурын өмнөх таслах хаалтыг бүрэн хааж, шугам хоолойг юулсэн байна.

3.21. Хэрэглэгчид суурилагдсан, хэрэглэгчийн уурыг хэмжиж байгаа тоолуур хэмжих хэрэгсэл ашиглалтын явцад эвдрэл гэмтэл гарсан, ээлжит баталгаажилтанд тэнцээгүй тохиолдолд тоолуур хэмжих хэрэгсэлийг ажилд оруулах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.

3.22. Хэрэглэгчид суурилагдсан тоолуур хэмжих хэрэгсэлийг Стандартчилал Хэмжил Зүйн газарт баталгаажуулах баталгаажуулалтын төлбөрийг хэрэглэгч хариуцна.

3.23. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд эрчим хүч хэрэглэх гэрээ байгуулах, сунгуулахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.23.1. Шинэ хэрэглэгч хангагчаас техникийн нөхцөл авах, хуучин хэрэглэгчийн техникийн нөхцлийн үйлчлэх хугацаа хүчинтэй байх.

3.23.2. Эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй байх

3.23.3. Барьцааны төлбөрийг төлсөн байх

3.23.4. Хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээ хийх, сунгуулах тухай бүрд өөрийн байгууллагын гэрчилгээний хуулбарыг гэрээнд хавсаргасан байх.

3.23.5. Гэрээнд хавсаргах бусад материалуудыг бүрэн бүрдүүлсэн байх.

3.24. Жил бүрийн 7-р сарын 20-ны дотор дараа жилийн уурын дулааны эрчим хүчний хэрэглээний захиалгыг хангагчид гаргаж өгөх үүрэгтэй.

## Дөрөв. Төлбөрийн нөхцөл, торгууль ноогдуулах

4.1. Хэрэглэгч нь тухайн сарын захиалгын дагуу авах дулааны эрчим хүчний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг хангагчийн дансанд хийж байршуулсаны дараа эрчим хүчээр хангана.

4.2. Хангагч нь хэрэглэгчийн хэрэглэсэн эрчим хүчний бичилтийг сард нэг удаа хийх бөгөөд хэрэглэгч нь эрчим хүчний төлбөрийг хавсралтад заагдсан хугацааны дотор багтаан төлж барагдуулна.

4.3. Тоолуургүй хэрэглэгчийн дулааны тооцоог хийхдээ дулааны холболтын техникийн нөхцөлд заасан цагийн ачааллыг үндэслэн, амралтын өдрүүдийг ажлын өдөрт тооцон, ажиллах цагийг 8-аар авч, үлдсэн 16 цаг нь цагийн ачааллын 30 хувиар бодож тооцно. Гэхдээ ажилласан цаг, ачааллыг дунджаас хэт өндөр ажилласан эсэхэд хяналт тавьсан албан тушаалтны дүгнэлтийг үндэслэнэ. Ажилласан хоногийг албан бичиг өгч уур хаалгаж, нээлгэсэн хугацаагаар тооцно.

4.4. Дулааны эрчим хүч хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгсэл гэмтэж ажиллагаагүй болсон, хэмжих хэрэгслийн тэжээлийг тасалсан тохиолдолд тооцоо хийхдээ уг хэмжүүрийн хэвийн ажиллаж байсан үеийн заалтыг үндэслэж нөхөж тооцно. Тоолуур хэмжих хэрэгсэл сүүлийн 3 сар хэвийн ажиллаагүй болон үйлдвэрийн ачаалал тогтмол биш байсан бол дулаан холболтын техникийн нөхцөлд заасан цагийн ачааллаар тооцож, тооцоонд авна.

4.5. Хэрэглэгч нь технологийн уур хэрэглээгүй /даралт, температур үүсээгүй/ үед тоолуурт зарцуулалтын хуурмаг заалт үүссэн тохиолдолд тоолуурын архиваас хуурмаг заалтыг хасаж тооцно.

4.6. Дулаан зөөгчийн үнийг **100%**-иар, Шугамын алдагдлыг **20%**-иар тооцно.

4.7. Тоолуур хэмжих хэрэгслийг СХЗГ-т магадлан шалгалтанд оруулж шалгуулахад гарах зардлыг магадлан шалгалт хийлгэх хүсэлт тавьсан тал хариуцна.

4.8. Хэрэглэгч нь энэ гэрээний хавсралтанд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд Эрчим хүчний тухай хуулийн 31.3-д заасны дагуу хугацаа хожимдуулсан хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх хэмжээний алданги оногдуулна.

4.9. Нийт алдангийн хэмжээ нь төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 50%-иас хэтрэхгүй байна.

4.10. Хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол Эрчим хүчний тухай хуулийн 29.1.7 –д заасныг үндэслэн эрчим хүчээр хангах гэрээг цуцлаж бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

4.11. "Дулааны эрчим хүчний төлбөр тооцох журам"-ын 3.11.-т заасны дагуу тухайн сард төлсөн төлбөрийг тооцохдоо урьд сард гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүй төлбөрийн үлдэгдэл болон алдангийг эхний ээлжинд төлснөөр тооцон суутгаж зөрүүг тухайн сарын төлбөрт тооцно.

4.12. Хэрэглэгч эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн болохыг хангагчийн эрх бүхий ажилтан илрүүлсэн бол нөхөн тооцоог суурилагдсан хүчин чадлаар нь тооцож, төлбөрийн хэмжээг тогтооно.

4.13. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийдэг ажилтны буруугаас гарсан зөрүүг гэрээт талууд харилцан тохиролцож, дараа сарын тооцоонд тайлбартайгаар тусгаж нөхөн тооцоог хийнэ.

4.14. Хангагчийн буруутай үйл ажиллагаанаас хэрэглэгчид хохирол учруулсан бол хоёр тал хамтран тогтоож баталгаажуулсан актыг үндэслэн хохирлын төлбөрийг хэрэглэгчийн уурын дулааны эрчим хүчний төлбөрөөс хасч тооцно.

**Үнэ тариф**

4.15. Гэрээт талууд Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор баталсан үнэ тарифыг мөрдөж ажиллана.

4.16. Хангагч, хэрэглэгчийн хооронд хийх эрчим хүчний хэрэглээний төлбөрийн тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тоолуурын заалтыг үндэслэн батлагдсан тарифаар тооцно. Үнэ тариф өөрчлөгдсөн тохиолдолд хангагч нь хэрэглэгчид тухай бүр мэдэгдэнэ.

4.17. Хангагчаас хэрэглэгчид үзүүлэх зарим үйлчилгээг батлагдсан тарифийн дагуу төлбөртэй гүйцэтгэнэ.

4.18. ЭХЗХ-ны Зохицуулагчдын зөвлөлөөс баталсан үнэ тариф өөрчлөгдөхөөс 15 хоногийн өмнө хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр шинэчлэгдсэн үнэ тарифыг зарласан байх бөгөөд хангагчийн зүгээс хэрэглэгчид үнэ тарифын өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүрт хүргэнэ. Мэдээлэл хожимдох нь энэхүү үнэ тарифыг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

4.19. Хэрэглэгчийн болон хангагчийн хүсэлтээр уурын дулааны эрчим хүчний хэрэглээг нээх, хаах үйлчилгээг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан төлбөрт үйлчилгээний үнэ тарифын дагуу төлбөртэйгээр хийж гүйцэтгэнэ. Тарифт үйлчилгээний төлбөрийг уурын ДЭХ-ний төлбөртэй хамт төлнө.

**Тав. Эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлэх**

5.1. Эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан дараах тохиолдолд хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээний зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

Үүнд:

5.1.1. Эрчим хүч хэрэглэсний төлбөрөө төлөөгүй,

5.1.2. Эрчим хүчний тооцооны тоолуур, хэмжүүр тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан,

5.1.3. Хэрэглэгч нь хангагчийн зөвшөөрөлгүйгээр дулааны холболтын техникийн нөхцөл болон, гэрээнд заагдаагүй хэлбэрээр дулааны эрчим хүч хэрэглэсэн

5.1.4. Хангагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хэрэглээний хүрээнээс өөр хэрэглэгчийг эрчим хүчээр хангасан.

5.1.5. Хангагчийн эрх бүхий ажилтныг өөрийн байранд нэвтэрч үзлэг, шалгалт, тооцоо хийх боломж олгоогүй.

5.1.6. Байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн, түлшний хомсдол бий болсон, эрчим хүчний хангамжид осол, саатал гарсан хүний амь нас эд хөрөнгөнд аюул учрах, гал түймэр гарах нөхцөл үүссэн.

5.2. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч энэ гэрээний 5.1-д зааснаас гадна дараах тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

5.2.1. Хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон.

5.2.2.Эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл зөрчсөн.

5.2.3.Эрчим хүчний улсын хяналтын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтан нь хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх болсон талаар хэрэглэгчид 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэл өгөх ба түдгэлзүүлэх болсон үндэслэлээ тодорхой зааж, тоног төхөөрөмж, тоолуур, хэмжүүр, бусад шаардлагатай хэрэгслийг битүүмжилнэ.

5.2.4. Эрчим хүчний улсын хяналтын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтан нь энэ гэрээний 5.1.6-д заасан нөхцөл үүссэн үед хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг урьдчилан мэдэгдэхгүйгээр түдгэлзүүлж болно.

5.2.5.Хэрэглэгч нь эрчим хүчний хэрэглээгээ түдгэлзүүлсэн зөрчлөө арилгасан тухайгаа эрчим хүчний улсын байцаагч болон хангагчийн эрх бүхий ажилтанд шалгуулахаас өмнө битүүмжилсэн тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглахыг хориглоно.

5.3. Хэрэглэгчийн хэрэглээг түдгэлзүүлэх хангагчийн эрх бүхий ажилтан нь түдгэлзүүлэх тухай шалтгааныг 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэх бөгөөд шууд түдгэлзүүлэх эрхгүй.

## Зургаа. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас

6.1. Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Уг зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барихыг хориглоно.

6.2. Хамгаалалтын зурвасыг дүүргийн засаг дарга тогтоох ба уг зурваст шугам сүлжээнд гэмтэл учруулахаар буюу үзлэг үйлчилгээнд саад болохоор ургасан ба тарьсан мод бутыг өмчлөгч огтлох, шилжүүлэн суулгах үүрэгтэй.

6.3. Хангагчийн эрх бүхий ажилтан шугам сүлжээнд үзлэг үйлчилгээ хийх, хяналт хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасын дагуу бусдын эзэмшил, ашиглалтанд байгаа газар, барилга байгууламжид нэвтрэн орох, дайран өнгөрөх, эзэмшигч нь үүргээ биелүүлээгүй бол мод бутыг шилжүүлэн суулгуулах, боломжгүй бол огтлуулах эрхтэй.

6.4. Гэрээг үйлчлэх хугацаанд байгалийн гамшиг /аянга, гал түймэр, усны үер, хүчтэй салхи, мөсдөлт гэх мэт/ дайн байлдаан, хүний амь нас, эд хөрөнгөнд аюул учрах нөхцөл үүссэн, ажил хаялт зарласан зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан учирсан хохирлыг гэрээнд оролцогч талууд хариуцахгүй.

6.5. Талууд цаг агаарын онцгой нөхцөл байдалд ажиллах журмыг баримтлан гарсан ааварийг богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээг авч ажиллах бөгөөд эрчим хүчний хангамжийг сэргээхэд шаардагдах хугацаа, залгалт хийж эхлэх цаг хугацааг харилцан шуурхай мэдээлж ажиллана.

## Долоо. Хяналт , хариуцлага, маргааныг шийдвэрлэх

### 7.1. Хяналт:

7.1.1. Энэхүү гэрээнд заасан үйл ажиллагаа, гэрээний нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хянах зорилгоор хангагч байгууллагын эрх бүхий ажилтан дараах чиглэлээр мэргэжлийн хяналт тавина.

- Хэрэглэгчдийн тоног төхөөремж нь засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж байгаа байдал, түүний хэрэгжүүлэлтэнд хяналт тавих
- Эрчим хүчийг зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэхэд болон шугам сүлжээг хамгаалах шаардлагыг мөрдүүлэхэд хяналт тавих.

7.1.2. Хангагч байгууллага нь өөрийн санаачлагаар болон бусад этгээдээс гаргасан гомдол хүсэлтийн дагуу гэрээнд заасан үйл ажиллагааг хянаж, шалгаж болно.

7.1.3. Хэрэглэгч гэрээний нөхцөл шаардлагыг зөрчсөн эсвэл биелүүлээгүй бол уг зөрчлийн талаар мэдсэнээс хойш 24 цагийн дотор хангагч, хэрэглэгчид утсаар мэдэгдэнэ.

7.1.4. Эрчим хүчний чанар стандарт, төлбөр тооцоотой холбоотой гомдлоо хэрэглэгч нь 48 цагийн дотор хангагчид бичгээр мэдэгдэнэ.

7.1.5. Хангагч нь энэ гэрээний 7.1-д заасан гомдлыг хүлээн авснаас хойш уг асуудлыг 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

7.1.6.Хэрэглэгч нь гэрээний зөрчил, параметрийн хэлбэлзлэлийн тухай 343097 дугаарын утсаар станцын ээлжийн инженерт болон 70111300 дугаарын утсаар станцын уурын хэсэгт мэдэгдэнэ.

**7.2. Маргааныг шийдвэрлэх:**

7.2.1. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийсэн ажилтны буруугаас гарсан маргааныг хөөн хэлэлцэх хугацаа нь төлбөр тооцоо бодогдож гарсанаас буюу техник технологитой холбоотой маргаан үүссэнээс хойш 48 цагийн дотор байх бөгөөд хэрэглэгч хангагчид албан ёсоор мэдэгдэж хангагч 7 хоногийн дотор хэрэглэгчтэй хамтран шийдвэрлэж тооцооны үнийн зөрүүг актаар тогтоож дараа сарын тооцоонд залруулан тусгана.

7.2.2. Уурын дулааны эрчим хүч тасалдсанаас болон чанарын үзүүлэлтийн хэлбэлзлэлээс үүссэн маргаан (хохирол)-ыг шийдвэрлэхдээ хангагч, хэрэглэгчийн эрх бүхий албан тушаалтнууд (комисс) 24 цагийн дотор хамтран хохиролын хэмжээг тогтоож акт үйлдэн баталгаажуулсан байна. Уг актанд хохиролыг барагдуулах хувь хэмжээг зааж өгөх ба түүнийг үндэслэн асуудлыг шийдвэрлэнэ.

7.2.3. Хангагч, хэрэглэгч хоёр нэг шийдвэрт хүрч чадахгүй бол дараагийн шатны байгууллагад хандан уг маргааныг шийдвэрлүүлнэ.

7.2.4. Эрчим хүчний хангамж, төлбөр тооцоо, хэмжих хэрэгсэл, бусад асуудлаар хэрэглэгчээс ирүүлсэн санал гомдлыг журмын дагуу шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

7.2.5. Гэрээтэй холбогдож үүссэн маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд эс хүрвэл тухайн байгууллагын маргаантай асуудал ямар байгууллагын эрх хэмжээнд хамаарахыг харгалзан Эрчим хүчний зохицуулах хороо болон шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.2.6. Хэмжих хэрэгсэл, тоолуурын ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ шаардлагатай бол Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвийн улсын байцаагчаар дүгнэлт гаргуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

**7.3. Хохирлыг нөхөн төлөх:**

7.3.1. Энэ гэрээний 5.1-д зааснаас бусад зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулах үед хангагч нь хэрэглэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр эрчим хүчийг таслаж хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлнө. Хохирлын төлбөр тооцоог энэ гэрээний 7.2.2-т заасан актыг үндэслэн хийнэ.

7.3.2. Системийн болон бусад гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас болж, хэрэглэгчид хохирол учирсан бол хангагч хохирлыг хариуцахгүй.

7.3.3. Энэ гэрээний 5.1-р заалтад заасан үйл ажиллагааг явуулахдаа урьдчилан мэдэгдсэн байхад хэрэглэгч өөрийн буруугаас хохирол хүлээсэн бол эрчим хүчээр хангагч хариуцахгүй.

7.3.4. Хангагч, хэрэглэгчийн хооронд эрчим хүчний хангамж, хэрэглээтэй холбогдож гарсан хохирлыг талууд хамтран акт тогтоож баталгаажуулах бөгөөд актыг үндэслэн буруутай тал нь 1 сарын дотор хохирлыг нөхөн төлнө.

**7.4. Хариуцлага:**

7.4.1. Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомж дүрмийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ. Гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн эсэхийг үл харгалзан учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

7.4.2. Гэрээний үүргээ зөрчсөн буюу биелүүлээгүй бол Эрчим хүчний тухай хууль бусад холбогдох хууль, дүрэм, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

## Найм. Бусад нөхцөл

8.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба талууд гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээний үйлчлэл дуусгавар болно.

8.2. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний нөхцлийг өөрчлөх шаардлага гарвал талуудын харилцан зөвшилцөж, албан ёсоор бичгэн хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж гарын үсэг зурж, тамга дарснаар баталгаажсанд тооцно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

8.3. Талууд энэхүү гэрээнд тусгагдаагүй асуудлыг мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.4. Харилцагч талууд гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлсэн компани, хувь хүмүүсийг харилцан шагнаж урамшуулж болно.

8.5. Гэрээг Монгол хэл дээр 2% үйлдэж, талууд тус бүр 1%-ийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй байна.

8.6. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний үүргийн биелэлтийг хамтран дүгнэж, 2% акт үйлдэнэ.

## Ес. Мэдээлэл, параметрүүд

9.1. Хангагчийн Уурын параметр: /Станцын коллекторт/

- 4-р сарын 15-наас 10-р сарын 15-н хүртэл P=8-11 ата, T=290°C
- 10-р сарын 15-наас 4-р сарын 15-н хүртэл P=6 ата, T=290 $^0$c байна.

Хэрэглэгчийн захиалга: P= 4-5 ата T= 150-160°C

9.2. Уурын дулааны эрчим хүчний тооцоо, төлбөр хийх хугацаа

| д/д | Агуулга | Хуанлийн өдрүүд |
|---|---|---|
| 1 | Сар бүрийн тоолуурын заалт авах өдөр | 1 – 5 |
| 2 | Төлбөрийн нэхэмжлэх хүрсэн байх өдөр | 8 – 10 |
| 3 | Тухайн сарын уурын төлбөрөө төлсөн байх сүүлийн өдөр | 20 |
| 4 | Алданги тооцож эхлэх өдөр | 21 |

9.3. Хангагч талын мэдээлэл

| | |
|---|---|
| Нэр: | Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК |
| Хаяг: | 17070, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө |
| Вэб сайт: | www.tes3.energy.mn |
| И мэйл хаяг: | thermalpowerplant3@gmail.com |
| Утасны дугаар: | Төлбөр тооцоотой холбоотой асуудлаар (ажлын цагаар) - 70111320<br>Тоолуур хэмжих хэрэгсэл, эрчим хүчний хангамжтай холбоотой асуудлаар - 70111300 (уурын хэсэг), 343097 (жижүүрийн инженер) |

9.4. Банкны харилцах данс

| № | Банкны нэр | Дансны дугаар |
|---|---|---|
| 1 | Хаан банк | 5020501745 |
| 2 | Голомт банк | 1102037031 |
| 3 | Худалдаа хөгжлийн банк | 406001038 |
| 4 | Худалдаа хөгжлийн банк | 2603001370 |
| 5 | Төрийн банк | 105400001612 |
| 6 | Хас банк | 5002864888 |
| 7 | Капитрон банк | 3004011490 |

**Хэрэглэгч талын мэдээлэл**

Нэр: "Лоро пъяна монгол" ХХК
Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр – 1, Үйлдвэрийн гудамж 41
Утасны дугаар: Байгалмаа – 99192549
Банкны нэр:
Электрон шуудангийн хаяг: Mongolia.office@loropiana.com

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Л.НЯМХҮҮ

САНХҮҮ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
Т.ЭНХТӨР

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЛБАНЫ ДАРГА
Л.БӨХБОЛД

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ЛХАМСҮРЭН

БОРЛУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Т.ГЭРЭЛТ-ОД

УУРЫН ХЭСГИЙН ДАРГА
Б.ЗОЛЗАЯА

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН
Г.БАТНЯМ

ХЯНАСАН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ц.ОЮУН-ЭРДЭНЭ

ТЕХНИК УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Д.БАТНАСАН

НЯГТЛАН БОДОГЧ
Ц.БАЙГАЛМАА

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ



# ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

/Аж ахуйн нэгж, байгууллага/


Хаяг: Улаанбаатар-36, Хан-Уул дүүрэг
Чингисийн өргөн чөлөө-45
Web: www.tog.mn
E-mail: info@ubedn.mn


ГЭРЭЭНИЙ ДУГААР: 118320
ХЭРЭГЛЭГЧИЙН НЭР: Лоро-Пиана Монгол ХХК
ХЭРЭГЛЭГЧИЙН КОД: 1100622
РЕГИСТРИЙН ДУГААР: 2046237

# ХАРИЛЦАХ СУВГУУД



# my.tog.mn

**ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ**
https://my.tog.mn

**ДУУДЛАГЫН ТӨВ**
7004 - 7004

**МЭССЭЖ ЛАВЛАХ**
137004

**ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВҮҮД**

**FACEBOOK.COM/UBEDN**

**TWITTER.COM/UBEDN1**

**CALLCENTER@UBEDN.MN**



## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

**/ААН/**

Гэрээг нэг талаас УБЦТС ТӨХК-ийг төлөөлж ...Хан-Уул... Хэрэглэгчдэд Үйлчлэх Төвийн...эрэмчин...ажилтан...Г...овогтой...Дашбалбар... /цаашид **Хангагч** гэх/, нөгөө талаас хоро Пэтро ААХ...-ийн үйл ажиллагаа эрхэлдэг ...ТУЗ-ийн борлуулалт-д...ажилтай ...Дамдиндорж... овогтой ...Бат-Эрдэнэ... /цаашид **Хэрэглэгч** гэх/ нар Монгол Улсын “Иргэний хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч - хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, Монгол Улсын стандарт “Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага”-ыг үндэслэн ...ХУ..... (дүүрэг,аймаг)....3...-р (хороо, сум)-ын Гоео ХК-ийн ...үйлдвэр (хороолол, баг)-ын.............(байр, гудамж)................... тоот үл хөдлөх хөрөнгө /объёкт/-ийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор...2021.... оны ...8.... сарын .02.... –ээс ..5..... жил /бичгээр ..тав....../-ийн хугацаатай дор дурьдсан нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Тус компанитай “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ” байгуулах хэрэглэгч нь шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлтэй, цахилгаан эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй, хэрэглэгчдийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийлгэсэн байна.

1.2 Энэхүү гэрээг үл хөдлөх хөрөнгө өмчлөгчтэй байгуулах тохиолдолд хамтран хариуцагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулна. Харин үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч, түр оршин суугчтай байгуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр давхар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

1.3 Төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, хамтран хариуцагч, түрээслүүлэгч, түрээслэгч, түр оршин суугч нар нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.

1.4 Талууд энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдсон гэрээний нөхцөлд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын “Иргэний хууль”,

бол хангагч дангаар гэрээг сунгаж баталгаажуулна. Энэ тохиолдолд гэрээний хугацааг сунгагдсанд тооцож, хүчин төгөлдөр гэрээ гэж үзнэ

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД

| ХАНГАГЧ | ХЭРЭГЛЭГЧ |
|---|---|
| УБЦТС ТӨХК-ийн Хан-Уул | Лоро Пэлжа Монгол ...... ажилтай |
| ХҮТ-ийн дарга ........ | захирал ........ |
| ........ | /______________/ (гарын үсэг) |
| /______________/ | Хамтран хариуцагч |
| ХҮТ-ийн Г.Дашбалбар ажилтан | ........ |
| ........ | Түрээслэгч |
| /______________/ | ........ /______________/ |
| Утас: 70047004 | Утас: 99124436 |
| Хаяг: ХУД 3 хороо | Хаяг: ХУД 3 хороо |
| УБ-36 ........ | Бэёо ХК-н ург |

Тамга: Лоро Пэлжа Монгол ХХК, Улаанбаатар, УХН3328





**НЭГДҮГЭЭР хавсралт**

### Хангагч, хэрэглэгч хоорондын эзэмшлийн зааг

1. Талуудын эзэмшлийн заагийг .......... хувилбараар тогтоов.

   Техникийн нөхцлийн дугаар ...................... огноо ........................

Хэрэглэгчийн хүчний трансформаторын суурилагдсан чадал _____ кВА

Хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн суурилагдсан чадал _____ кВт

Гэрэлтүүлгийн чадал _____ кВт

Нийлбэр чадал _____ кВт

1.1 Агаарын болон кабель шугамын холболтоор зааглах схем




1.2 Трансформаторын дэд өртөөнөөс 0,4 кВ-ын шугамаар тэжээгдэж буй хэрэглэгчдийн шугам, тоноглолыг зааглах схем




1.3 Компанийн хуваарилах байгууламжаар дамжин тэжээгдэж буй хэрэглэгчийн дэд өртөөг зааглах схем

1.3.1




1.3.2



**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ**

# ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2022-05-12 Дугаар: 0002183 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ЛОРОПЬЯНА МОНГОЛ ГХО ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9019011059
Регистрийн дугаар: 2046237
Хаяг: Хан-Уул, 3-р хороо, Чингэсийн өргөн чөлөө, Өөрийн байр-00

Утас: 343533, 343529

**Дараах химийн хортой, аюултай бодис:**
Импортлох, ашиглах **аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг** 2022.05.12-2025.12.31 **хүртэл хугацаагаар олгов.**

| № | Бодисын нэр | | Томъёо | Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/ | Ангилал | Үйлдвэрлэсэн улс | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Монгол | Олон улсын | | | | | |
| 1 | Ноолуур угаах саван Теридол В Конк | Teridol B Conc Alkyl Poly-coethers | | 98951-67-7 | | | 9 тн |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |

**Улсын хилээр нэвтрүүлэх боомт:** Алтанбулаг, Сүхбаатар

**Зөвшөөрөл олгосон:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга
/ Э. БАТТУЛГА /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
/ Ц.БАТЖАРГАЛ /

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
**ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА**

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр,
Утас: 7000-3714, Факс: (976) 7000-3714
E-mail: TuulRBA@gmail.com

2023.11.23 № 04/661

танай 2023.11.01 -ны № А170/23 -т

"ЛОРО ПЬЯНА МОНГОЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.БУЯНДЭЛГЭР
ТАНАА

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалт, танай компанийн 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/170/23 дугаар хүсэлтийг тус тус үндэслэн ноос, ноолуур угаах үйлдвэрийн 2023 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

Ус ашиглуулах дүгнэлтээр тавигдсан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хувийг, Нийслэлийн Байгаль орчны газар, Хан-Уул дүүргийн Татварын хэлтэст.

Хавсралт 3 хуудастай, 2 хувь.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.НЯМДОРЖ

5633648
УЖА0053

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
"ЛОРО ПЬЯНА МОНГОЛ" ХХК-ИЙН
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

*2023 оны .11. дугаар сарын 23.-ын/ийн өдөр* *Дугаар УАД 23/.19* *Улаанбаатар хот Утас: 7000-3716, 7000-3714*

***1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас, улсын бүртгэлийн дугаар болон регистрийн дугаар:***
*- "Лоро пьяна монгол" ХХК, Гүйцэтгэх захирал А.Буяндэлгэр, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингэсийн өргөн чөлөө, өөрийн байр-00, Утас:9979-9364, 8815-2961 УБД-9019011059, РД-2046237.*

***2. Төслийн байршил, харьяалагдах сав газар:***
*- "Лоро пьяна монгол" ХХК-ийн ноос, ноолуур угаах анхан шатны үйлдвэр нь Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Туул голын сав газарт хамрагдана.*

***3.Төсөл хэрэгжүүлэгч:***
*- "Лоро пьяна монгол" ХХК.*

***4.Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн хэмжээ, координат /Х;У/:***
*- Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/1589 дугаар шийдвэрээр олгосон, 2206009420 тоот гэрчилгээтэй 10'980.0 м² газрыг 5 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшдэг.*

***5.Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:***
*- Үйлдвэр нь ноос, ноолуур угаах, чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг.*

***6. Үйлдвэрийн техник, технологи ажиллах горим, хүчин чадал:***
*- Үйлдвэр нь БНХАУ-ын бүрэн тоног төхөөрөмжтэй. Үйлдвэрлэл нь түүхий эд хүлээн авах, ангилан ялгалт хийх, бутлах, сэмлэх, угаах, хатаах, савлах гэсэн технологиор үйл ажиллагаа явуулдаг. Жилд 352'200.0 кг ноолуурын анхан шатны боловсруулалтыг хийж экспортод гаргах хүчин чадалтай. Үйлдвэр нь 1-12 сарууддад үйл ажиллагаа явуулж, жилд дунджаар 260 хоног ажиллана. 40 ажилтантай.*

***7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:***
*- 2023 онд үйлдвэр нь жилдээ 240.0 тонн ноос, ноолуур угаахаар төлөвлөсөн.*

***8. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ:***
*- Үйлдвэрийн усан хангамжийг төвлөрсөн системээс болон өөрийн эзэмшлийн 50 м гүнтэй 1 худгаас хангадаг. Үйлдвэр нь Ус сувгийн удирдах газрын 2023 оны хэрэглэгчийн тооцооны хуудсаар хоногт дунджаар 61.5 м³ ус ашиглаж байна.*

***9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/:***
*- Үйлдвэр нь цагт 550 м³ хаягдал бохир ус цэвэрлэх хүчин чадалтай урьдчилан цэвэрлэх байгууламжтай. Үйлдвэрийн ус хангамжийн зориулалтаар гаргасан 1 гүний худагтай, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.*

***10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосын хүчин чадал, марк/:***
*- Ус сувгийн удирдах газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр цэвэр, бохир усны тооцоо хийдэг.*
*- Худагт Стандарт, хэмжил зүйн газраас 2022 оны 07 дугаар сард баталгаажуулсан LXLG загварын 40 мм-ийн голчтой 1001002717 дугаартай тоолуур суурилуулсан.*
*- Төвлөрсөн шугамын орох хоолой LXSG-50 загварын 201700729, LXSG-25 загварын 161800055, DH-50 загварын 009920 дугаартай усны тоолуур суурилагдсан.*

***11. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл:***
*- Үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2018 онд "Сайхан ариун дэлхий" ХХК гүйцэтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан байна. Цаашид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.*

***12. Онцгой нөхцөл:***

*- "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаас давсан бохирдолтой хаягдал усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн тохиолдолд Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах нөхцөл үүсэхийг анхаарах;*

*- Ус хангамжийн худгаас улирал бүр дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж, "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох, шинжилгээний дүнг тайланд хавсаргаж, Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.*

***13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:***

***- 2023 оны ус ашиглалтыг тооцоход:***

*- Үйлдвэр нь жилд 240.0 тонн ноолуур угаахаар төлөвлөсөн. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор урьдчилан тооцов.*

*1 тонн ноолуур угаах боловсруулахад ашиглах усны хэмжээ-66.7 м$^3$.*

***2023 онд ашиглах үйлдвэрийн усны хэрэглээг урьдчилан тооцоход:***

*240.0 тн х 66.7 м$^3$ = 16'008.0 м$^3$/жил.*

***14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилан байдлаар тооцоход:***

*- Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан "Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ", Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ", Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор батлагдсан "Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр"-ийг тус тус үндэслэн тооцоход:*

***Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах 1 м$^3$ усны нөөцийн төлбөрт:***

*9'440 төг/м$^3$ х 0.1 х 10% = 94.40 төгрөг*

*9'440 төг/м$^3$–Туул голын сав газар дахь газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;*

*10% –Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;*

*0.1– Ашиглалтын зориулалтын итгэлцүүр.*

***2023 онд ашиглах усны нөөцийн төлбөрт:***

*16'008.0 м$^3$ х 94.40 төг = 1'511'155 /Нэг сая таван зуун арван нэгэн мянга нэг зуун тавин таван/ төгрөг*

*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтад заасны дагуу (94.40 төг) усны тоолуурын заалтаар Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.*

***15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:***

*- Урьдчилан цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн хаягдал усны цэвэршилт 20-30 хувь байдаг тул үйлдвэрийн технологийн дамжлагад эргүүлэн ашиглаж байна.*

***16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:***

*- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтад заасны дагуу Нийслэлийн байгаль орчны газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллах шаардлагатай;*

*- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах;*

*- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5 дахь заалтын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2 дахь заалтад заасны дагуу тухайн дүүргийн Татварын хэлтэст төвлөрүүлэх шаардлагатай;*

*-Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18 дахь заалтын дагуу ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно;*

*- Гэрээнд заасснаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцохыг анхаарах;*

*- Усны тоолуурын заалтын баталгаа алдагдсан, тоолуурыг шугам хоолойноос салгасан, тоолуургүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын Сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцож ногдуулахыг анхаарах;*

*- Ус ашиглуулах дүгнэлтээр ногдуулсан усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг хугацаанд нь төлөхгүй үйл ажиллагаа явуулбал Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15 дахь заалтын дагуу хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарч ажиллах;*

*- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтад заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тайланг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлж ажиллах;*

*- Үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар зогсолт хийсэн, эргэн ажиллах тухай бүрд холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж оруулах;*

*- Ус ашиглуулах дүгнэлт болон хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний хагас жилд багтаан жил бүр гаргуулж байхыг анхаарах.*

**ХЯНАСАН:**
УНУАЗА-НЫ ДАРГА П.ЭНХБАЯР

**БОЛОВСРУУЛСАН:**
УНУАЗА-НЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.УРАНЧИМЭГ

PRODUCED BY AN AUTODESK STUDENT VERSION

## Зааг эзэмшилийн зураг

Байгууллагын нэр: ЛОРО ПЪЯНА МОНГОЛ ХХК

PRODUCED BY AN AUTODESK STUDENT VERSION

PRODUCED BY AN AUTODESK STUDENT VERSION




| Ус Сувгийн Удирдах Газар | | Он | | Тэмдэглэгээ | |
|---|---|---|---|---|---|
| | | Сар | | Барилга | |
| | | Өдөр | | | |
| Хянасан | Ө.ДАШНЯМ | | | Хэрэглэгчийн хариуцах цэвэр усны шугам | |
| Тогтоосон | Т.БААСАНХҮҮ | | | Хэрэглэгчийн хариуцах бохир усны шугам | |
| Зөвшөөрсөн | А.БУЯНДЭЛГЭР | | | ЦУХ-ын тоо | 1 |
| | | | | БУХ-ын тоо | 11 |

PRODUCED BY AN AUTODESK STUDENT VERSION

# ГЭРЭЭ ХИЙХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэрэглэгчийн нэр ЛОРО ПЪЯНА МОНГОЛ ХХК

Факс:

Емэйл: loropianomongolia@mongol.net

Утас: 99115458, 99192549

Албантушаал:

- ЗАХИРАЛ А.БУЯНДЭЛГЭР
- Нягтлан Ц.Байгалмаа
- Менежер
- Инженер Д.Батнасан
- Бусад:

Улсын бүртгэлийн дугаар 9019011059

Хэрэглэгчийн регистрийн дугаар 2046237

Хэрэглэгчийн НӨАТ төлөгчийн гэрчилгээний дугаар №0689

Шуудангийн хаяг

Хаяг: Улаанбаатар - 06 Хан-Уул - 3 -р хороо үйлдвэрчний гудамж 41

Байршил: Улаанбаатар - 06 Хан-Уул - 3 -р хороо үйлдвэрчний гудамж 41 /автобус 1-ын баруун талд/

Хэрэглэгчийн харьцдаг банк: Худалдаа хөгжил

Дансны дугаар: 499023869

**Үйл ажилгааны чиглэл:**

| | |
|---|---|
| Төсөв: | |
| Аж ахуй: | |
| Орон сууц: | |
| Үйлдвэр: | |
| Бохирдуулагч үйлдвэр: | Ноос, ноолуур угаах |

**Холболт:**

| Цэвэр ус: | |
|---|---|
| Төвлөрсөн системээс | X |
| Гэр хорооллын шугам | |
| Гүний худагтай | |
| Зөөврөөр | |
| Бусад | |
| **Бохир ус** | |
| Төвийн коллекторт | X |
| Цооногтой | |
| Бохиргүй | |
| Бусад | |

**Бусад мэдээлэл:**

| | |
|---|---|
| Барилгын талбай м2 | 7141 |
| Давхрын тоо | 2 |
| Байрны тоо | 1 |
| Ажиллах цаг | 8 |
| Ажлын хоног | 26 |
| Хүний тоо | 0 |
| **Тоноглолуудын тоо** | |
| Угаалтуур | 0 |
| Суултуур | 0 |
| Ванн | 0 |
| Писсуар | 0 |
| Шүршүүр | 0 |

**Тоолуурын тухай**

| Тоолуурын дугаар | Тоолуурын голч /мм/ | Тоолуурын оронгийн тоо | Гэрчилгээний дугаар | Тоолуурын төрөл | Марк | Баталгаажсан огноо | Суурилуулсан огноо | Тоолуурын анхны заалт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 201700729 | 50 | 6 | 031593 | Хүйтэн | LXLC | 2019/11/22 | 2019/11/23 | 0 |
| 1001002717 | 40 | 5 | 115280 | Хүйтэн | DH | 2019/04/19 | 2019/04/23 | 0 |
| 1610000055 | 25 | 5 | 014798 | Хүйтэн | | 2018/11/20 | 2018/11/20 | 0 |
| 009920 | 50 | 7 | 116496 | Хүйтэн | G2-ES | 2019/04/25 | 2019/04/30 | 0 |
| | | | | | | | | |

**Хэрэглэгчийн гэрээний дугаар 26007800**

Төлбөрийн дүнг мессежээр хүлээн авах утасны дугаар: 99192549

Хэрэглэсэн усанд төлбөр тавих хугацаа: [X] Сар [ ] Улирал

Гэрээний төрөл: [X] Байнгын [ ] Түр

Гэрээ өөрчлөх болсон шалтгаан: Гэрээ шинэчилсэн

**Энэхүү хэсгийг УСУГ-ийн ажилтан бөглөнө.**

Техникийн нөхцлийн дугаар: 0

Цэвэр усны цагирагийн дугаар: 78

Бохир усны коллекторын дугаар: Өмнөдийн Ф1400

Оруулга шугамын голч /мм-ээр/: 108

Худгийн тоо:

Худгийн тоо:

Ө. Дашням (signature)

Ө.ДАШНЯМ

хангагчийн гарын үсэг

тамга

Лоро Пъяна Монгол ХХК УХН3328

А.БУЯНДЭЛГЭР

хэрэглэгчийн гарын үсэг

хүртэлх шугамын ашиглалт, урьдчилсан цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хариуцсан инженер болон ажилтантай байх.

16. Хэрэглэгч нь хангагчийн эрх бүхий ажилтнуудын биеийн байцаалтыг нь үндэслэн саадгүй нэвтрүүлж цэвэр, бохир усны шугам сүлжээ, усны тоолуурын зангилаа болон бусад үйл ажиллагааг шалгах нөхцөл бололцоогоор хангаж ажиллахын зэрэгцээ ажлын холбоотой тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллана.

17.Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилт болон MNS 5582:2006, MNS6561:2015 стандартыг хангах ажлын хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүр хангагч байгууллагад ирүүлэх.

18 .Энэхүү нэмэлт гэрээ нь 26007800 тоот гэрээний салшгүй хэсэг болно.

ХАНГАГЧ ТАЛААС: ХЭРЭГЛЭГЧИЙН ТАЛААС:

ХУА-НЫ ДАРГА: ..................... .....................

ГЭРЭЭНИЙ ИНЖЕНЕР: ..................... .....................

**Арьс шир боловсруулах,Ноос ноолуур угаах үйлдвэрүүдийн .. 26007800.. тоот аж ахуйн гэрээнд хэрэглэгчийн хүлээх нэмэлт заалт:**

1. Энэхүү чиглэлд хамаарагдах үйлдвэрүүд нь хүчин чадлаас үл хамааран урьдчилан цэвэрлэх байгууламж /тунгаагуур, элс тос баригч, шүүр, трап/ суурилуулсан байх.

2. Хэрэглэгч нь Засгийн газрын 73 дугаар тогтоол болон MNS 6561:2015 стандартыг мөрдөн ажиллах.

3. Дотор трап болон гаргалгаанд хөдөлгөөнгүй шүүр суурилуулж байнгын цэвэрлэгээ үйлчилгээ хийх.

4. Үйлдвэрийн дотор трап болон гадна худаг, тунгаагуурыг 7 хоногт 2-оос доошгүй удаа цэвэрлэх.

5. Улиралд 1 удаа гадна бохир усны шугамыг лайдаж, цэвэрлэн хангагч байгууллагын төлөөлөлд үзүүлэн актаар баталгаажуулах.

6. Бохир усны шугаманд нийлүүлж байгаа уурын конденсацийн илүүдэл усыг уурын тоолуурын тооцоог үндэслэн тогтооно. Уурын тоолуурын заалтыг тухайн дүүргийн хэсэгт сар бүр мэдээлж байх.

7. Цаашид үйлдвэрүүд нь 2 шатны 2 тунгаагуууртай байх. Тунгаагуурууды сэлгэн ажиллуулж цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж хэвших.

8. Хэрэв Урьдчилан цэвэрлэх байгууламжид технологийн хаягдал усаа нийлүүлдэг бол хром, сульфидын шугам салангид, тусдаа байх.

9. Одоо байгаа лагийн талбайг шаардлагын түвшинд хийх. Цаашид лагийг үнэргүйжүүлэх тал дээр тодорхой арга хэмжээ авч ажиллах.

10. Үйлдвэрүүд өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, технологи үйл ажиллагааны явцад гарч байгаа бохир уснаас сар бүр итгэмжлэгдсэн лабораториор дээж авахуулж шинжилгээ хийлгэн зөвшөөрөгдөх нормоос хэтрүүлэлгүй ажиллах.

11. Бохир уснаас сар бүр дээж авах үед хариуцсан ажилтнаа хамт байлцуулах.

12. Бохирдолтын хэмжээ нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд урьдчилан мэдэгдэж үйл ажиллагааг зогсооно.

13. Хэрэглэгч нь хангагчаас батлагдсан үнэ тарифын дагуу шинжилгээний төлбөрийг төлөх.

14. "Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 2.2 заалтыг үндэслэн "Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах" гэрээг жил бүр дүгнэн сунгана.

15. Цэвэр, бохир усны тоолуурын лац битүүмжлэл, тойрох шугам дээрх хаалт, хэмжих хэрэгслийн зангилаа, ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, тоног төхөөрөмж болон гадна цэвэр, бохир усны худаг, худаг

хийх, усны тоолуурын заалт авах, бохир усны дээж авч хэмжилт хийх, лац тавих, цэвэр усны горимын тооцоо хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэхэд санаатайгаар саад учруулсан тохиолдолд;

6.1.6 Тухайн хэрэглэгчийн эзэмшил дээрх ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн бүрэн бус байдлын талаар илэрсэн зөрчлийг арилгах шаардлагыг хүлээн авч биелүүлээгүй тохиолдолд;

6.2 Хангагч нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 16.1.1, 16.1.2, 16.1.3-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэглэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хязгаарлалт хийж болно;

## ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ГЭРЭЭ ДҮГНЭХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

7.1 Тус гэрээ байгуулсан өдрөөс эхлэн аль нэг талаас гэрээг цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө. /Энэхүү гэрээ нь анх 1998/09/02 -ны өдөр байгуулсан гэрээний үргэлжлэл болно/;

7.2 Хангагч, хэрэглэгч нь жилд нэг удаа гэрээг дүгнэж, дараа жилийн цэвэр бохир усны гэрээнд тодотгол хийнэ. /Энэхүү заалт нь гэрээ байгуулсан хугацаа болон хэрэглэгчийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарна/;

7.3 Хэрэглэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн тохиолдолд цаашид гэрээг сунгах эсэх асуудлыг хангагчийн техникийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ;

7.4 Хэрэглэгч нь аж ахуйн гэрээний 4.2.12 заалтыг хангаж ажиллаагүй нөхцөлд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээ цуцлах арга хэмжээ авна;

7.5 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргасан тал нь 14 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. /Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ/;

7.6 Хэрэглэгч нь цэвэр, бохир усны төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ 3 удаа биелүүлээгүй тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээг цуцлах арга хэмжээ авна;

7.7 Хангагч, хэрэглэгч нь аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдэлд хүрээгүй тохиолдолд шүүх, хууль хяналтын байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ;

Гэрээлэгчийн харилцах банк: Худалдаа хөгжил

Дансны дугаар : 499023869

Хангагчийн талаас:
Утас: 77117703
Факс: 70157074

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Хангагчийн талаас: ..................
ХУА-ны дарга
Гэрээний инженер ..................

Хэрэглэгчийн талаас:
( гарын үсэг)
..................

зөвшөөрөлгүй өргөтгөл хийх зэрэг асуудлыг хангагчийн зөвшөөрөлгүй хийхгүй байх;

4.3.11 Хэрэглэгч нь үйлдвэрийн гаргалгаанаас төвийн коллектор хүртэлх өөрийн эзэмшлийн бохир усны шугам, худгийг жилд 2 удаа буюу хавар, намрын улиралд сетик татан, лайдаж цэвэрлэн хангагчийн хяналтын инженер нараар шалгуулж, бохир усны шугам, худганд ээлжит цэвэрлэгээ, үйлчилгээ хийсэн тухай актанд гарын үсэг зуруулсан байна /энэ заалт нь энэхүү гэрээг байгуулах, дүгнэх, сунгахад гол үзүүлэлт болно/;

## ТАВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Хэрэглэгч өөрийн буруутай үйл ажиллагаанаас өөрт болон бусдад учруулсан хохирлыг бүрэн хариуцна;

5.2 Өөрийн ашигладаг тоног төхөөрөмжинд засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс хангагч болон бусад хэрэглэгчийн ус хангамжийн үйл ажиллагаа саатсан, доголдсон бол гарсан хохирлыг хэрэглэгч бүрэн барагдуулна;

5.3 Хангагч нь өөрийн буруугаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэрэглэгчийн ус хангамжийг тасалдуулсан бол тэр хугацаанд ноогдох усны төлбөрөөс чөлөөлнө;

5.4 Хэрэглэгч нь зөвшөөрөлгүйгээр буюу зөвшөөрөлгүй цэгт бохир ус нийлүүлсэн тохиолдолд "Ус бохирдуулсны төлбөрийн тухай" хуулийн 10 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ;

5.5 Хэрэглэгч нь энэхүү гэрээний заалтуудыг зөрчсөн тохиолдолд "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 23 дугаар зүйлд заасан хариуцлагыг нэгэн адил хүлээнэ;

## ЗУРГАА. ЦЭВЭР УСААР ХАНГАХ БА БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ, ЗОГСООХ НӨХЦЛҮҮД

6.1 Хангагч нь хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах ажиллагааг "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 16.2 дах хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хэсэгчлэн болон бүрэн зогсооно. Үүнээс гарах аливаа хохирлыг хангагч хариуцахгүй болно. Үүнд:

6.1.1 Хангагчтай байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн буюу гэрээний хугацаа дууссан зөрчил илэрсэн үед;

6.1.2 Усны үйлчилгээний төлбөрийг 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар тогтоосон хугацаанд төлөөгүй;

6.1.3 Хангагч байгууллагын зөвшөөрөлгүйгээр дамжин хэрэглэгчийг цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулсан тохиодолд;

6.1.4 Хангагчаас зохих зөвшөөрөл авсан дамжин хэрэглэгчийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбохоос үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд;

6.1.5 Хангагчийн эрх бүхий ажилтныг усны тоолуурын зангилаа, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид үзлэг шалгалт

тоног төхөөрөмжийн тохируулга, хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдал ба хэвийн ажиллагааг хангах;

4.2.18 Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшил бүхий шугам, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэмтэл саатал гарвал хангагчид нэн даруй мэдэгдэж, цэвэр ус дамжуулах болон түгээх шугам дээр хаалгах арга хэмжээ авах, аюулгүй, найдвартай ажиллагааг хангах;

4.2.19 Хангагчаас өгсөн зөвлөмж, тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас өөрийн буруутай үйл ажиллагаанаас шугам, тоноглолд гэмтэл гарч, бусад хэрэглэгчдэд хохирол учруулбал уг хохирлыг хариуцаж барагдуулах;

4.2.20 Үйлдвэрүүд нь үйлдвэрлэлийн байрандаа суваг /трап/ хийх бөгөөд 5-10м тутамд хөдөлгөөнтэй шүүр байрлуулах (савхны өргөн 0.5см, савхны өөр хоорондын зай нь 0.2см байх)

4.2.21 Үйлдвэр бүр стандартын тунгаагууртай байх, тунгаагуурын гаргалгааны сувагт байрлах хөдөлгөөнгүй шүүрний савхны өргөн нь 0.5см, савхны өөр хоорондын зай нь 0.2см 45 градусын налуу байрлалтай байна;

4.2.22 Технологийн үйл ажиллагааг сайжруулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад гарч буй бохир агаарыг үнэргүйжүүлэх байгууламжаар дамжуулан гаргах шинэ тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх;

4.2.23 Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилт болон MNS 5582:2006 стандартыг хангах ажлын хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүр хангагч байгууллагад ирүүлэх;

*4.3 Технологийн бохир усаа Урьдчилан цэвэрлэх байгууламжийн татах шугамд нийлүүлж байгаа үйлдвэрүүд:*

4.3.1 Хэрэглэгч нь НХБТГ-ын даргын 2013 оны А/85 дугаар тушаалын дагуу ус ашиглуулах зөвшөөрөл авсан байх;

4.3.2 Хэрэглэгч нь захиалагч байгууллагын түүхий эдийг боловсруулсан бол гэрээний хуулбарыг хангагч талд хүргүүлэх;

4.3.3 "Захиалгын хуудас"-ыг үнэн зөв гарган хангагчид өгөх;

4.3.4 Урьдчилгаа төлбөрийг хангагчийн дансанд бүрэн байршуулсан байх;

4.3.5 Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан цэвэр, бохир усны тоолууртай байх;

4.3.6 Үйлдвэрүүд нь өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, технологи үйл ажиллагааны явцад гарч байгаа бохир уснаас сар бүр итгэмжлэгдсэн лабораториор дээж авахуулж шинжилгээ хийлгэн зөвшөөрөгдөх нормоос хэтэрсэн үзүүлэлтүүдийг бууруулах арга хэмжээ авч ажиллах;

4.3.7 Хэрэглэгч нь батлагдсан үнэ тарифын дагуу шинжилгээний төлбөрийг төлөх;

4.3.8 Гүний худагтай хэрэглэгч нь гүний худгийн шугам дээрээ баталгаатай тоолуур тавих;

4.3.9 Баталгаажуулсан цэвэр, бохир усны тоолуурыг хангагчийн холбогдох ажилтнаар хянуулан, заасан цэгт нь суурилуулах боломжийг бүрдүүлэн, хэвийн ажиллах нөхцлөөр хангах;

4.3.10 Хэрэглэгч нь өөрийн узель шугам сүлжээний холболтыг дур мэдэн өөрчлөх, үйлдвэрийн технологийн болон ахуй хэрэглээг анх техникийн нөхцөл авч байх үеийн хэрэглээнээс нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн барилгад

зөвшөөрлөөр холболт хийх, холболтыг эрх бүхий ажилтаны хяналтан дор гүйцэтгэх;

4.2.4 Хэрэглэгч нь хангагчийн эрх бүхий ажилтнуудыг цэвэр, бохир усны шугам сүлжээ, усны тоолуурын зангилаа зэргийг шалгах, заавар зөвлөгөө өгөх нөхцөл бололцоогоор хангаж, ажлын үнэмлэхийг үндэслэн саадгүй нэвтрүүлэх;

4.2.5 Хэрэглэгчийн усны тоолуур нь эвдэрсэн тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэж, 5 хоногийн дотор хэвийн ажиллагаанд оруулах;

4.2.6 Хэрэглэгчийн цэвэр, бохир усны шугам нь дундын эзэмшлийн шугамтай холбогдсон бол уг шугамын засвар үйлчилгээг тухайн хэрэглэгчидтэй хамтран гүйцэтгэх;

4.2.7 "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15.1.9-д зааснаар хэрэглэгч өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, бололцоогүй бол хангагчаар хийлгэж, гарсан зардлыг төлөх;

4.2.8 Хэрэглэгч нь усны тоолуурт Стандарт хэмжил зүйн газрын улсын шалгагчийн тавьсан тохируулгын, хангагчаас тавьсан хяналтын лац битүүмжлэлийг хариуцахаас гадна тоолуурын байрлал, холболтыг дур мэдэн өөрчлөхгүй байх;

4.2.9 Хэрэглэгч нь технологийн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлэхдээ бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг баримтална;

4.2.10 Хэрэглэгч өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох, өөрчлөгдөх бүрт www.eus.mn сайт руу нэвтэрч өөрчлөлтийг хийх;

4.2.11 Хэрэглэгч байгууллага нь НӨАТ төлөгч бол Улсын бүртгэлийн гэрчилгээний нэр, НӨАТ төлөгчийн нэр, гэрээ байгуулагчийн нэр ижил байна;

4.2.12 Хэрэглэгч нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.10 заалт, хангагчаас олгосон техникийн нөхцөл, зөвшөөрөл, батлагдсан зураг төслийн дагуу өөрийн эзэмшлийн шугамаас бусад хэрэглэгчийг холбуулах үүрэгтэй;

4.2.13 Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи болон бусад хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;

4.2.14 Хэрэглэгч нь энэхүү гэрээний нэмэлт заалтанд тусгагдсан үүргийг гэрээний нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээнэ;

4.2.15 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цэвэр усны шугамын алдагдал, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хангагчаас тогтоосон хугацаанд засварлах;

4.2.16 Хэрэглэгч нь төвийн цэвэр усны 2.0 ата даралтыг өөрийн хэрэгцээт даралт болгон өргөж ажиллуулах;

4.2.17 Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшлийн цэвэр, бохир усны шугам, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, шугам тоноглол, барилга байгууламжид ус алдагдахаас сэргийлэн, техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллахаас гадна суурилагдсан

хэрэглэгчдийн хэрэглэсэн усны хоногийн дундаж хэрэглээг тооцон хуваарилах бөгөөд шугам сүлжээний заагийг нарийвчлан тогтоож гэрээнд хавсралтаар оруулсан байна.

3.3 *Технологийн бохир усаа Урьдчилан цэвэрлэх байгууламжийн татах шугамд нийлүүлж байгаа үйлдвэрүүд:*

3.3.1 Үйлдвэрүүдийн "Захиалгын хуудас"-ыг үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан "Ус хэрэглээний жишиг норм"-ын дагуу хэрэглэгдэх усны хэмжээг тогтоон батлагдсан тарифаар тооцож "урьдчилгаа төлбөр" төлөх төлбөрийн дүнг гаргаж үйлдвэрүүдэд нэхэмжлэл хүргэх;

3.3.2 Үйлдвэрүүд нь MNS 5582:2006 стандартыг хангасан, хангагчийн дансанд урьдчилгаа төлбөр байршуулсан, НХБТГ-аас олгосон ус ашиглуулах зөвшөөрөлтэй үйлдвэрүүдтэй **"Боловсруулах чиглэлийн үйлдвэр, аж ахуйн нэгжийг цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах"** гэрээ байгуулах;

3.3.3 Үйлдвэрүүдийн шинжилгээний дүн мэдээг хэрэглэгчдэд мэдээлэх ажлыг зохион байгуулах;

3.3.4 Хэрэглэгчээс "Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх технологийн хаягдал ус, техникийн шаардлага" MNS 5582:2006 стандартын шаардлагыг хангасан бохир усыг хүлээн авч механик болон химийн урьдчилсан цэвэрлэгээ хийж төвийн шугаманд нийлүүлэх;

3.3.5 Үйлдвэрүүдийн технологийн бохир усыг хүлээн авч урьдчилан цэвэрлэхдээ байгууллагаас батлагдсан техникийн горимыг мөрдөн ажиллах;

## ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 *Хэрэглэгчийн эрх*

4.1.1 Хэрэглэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан цэвэр, бохир усны тоолуур суурилуулах энэ талын мэдээллийг хангагч байгууллагаас авах;

4.1.2 Гэрээний 4.1.1–г гүйцэтгэсэн тохиолдолд тоолуурыг төлбөрийн хэрэгсэл болгох саналаа өгөх;

4.1.3 Технологийн бохир усанд хийгдэж байгаа итгэмжлэгдсэн лабораторийн дээж шинжилгээний хариутай танилцах;

4.1.4 Шаардлагатай тохиолдолд хангагчийн төлөөлөгчийг байлцуулан итгэмжлэгдсэн лабораторид давтан дээж өгөх;

4.1.5 Хэрэглэгч нь 6 ба түүнээс дээш сарын хугацаанд ус ашиглахгүй тохиолдолд энэ талаар хангагч байгууллагад албан бичгээр хандаж тухайн хугацаанд усны суурь хураамжаас чөлөөлөгдөх;

4.2 *Хэрэглэгчийн үүрэг*

4.2.1 Хэрэглэгч нь хүн амын унд-ахуйн стандартад тохирсон цэвэр усаар хангуулах, MNS 6561-2015 стандартын шаардлага хангасан бохир усыг төвийн шугамд нийлүүлэх;

4.2.2 Хэрэглэгч нь усны тоолуурын зангилаа, түүний бүрэн бүтэн байдал, ашиглалт засвар үйлчилгээг хариуцна;

4.2.3 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд зөвхөн хангагчийн

шаардлага, мэдэгдэх хуудас өгөх, төлбөр нэхэмжлэх, гэрээ цуцлах, цэвэр усны хангамжийг хязгаарлах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

3.1.9 Төлбөр тооцооны хэмжих хэрэгсэл түүний битүүмжлэл, лац, холболтыг дураар өөрчилж, хэвийн ажиллагааг алдагдуулсан, зохих зөвшөөрөлгүйгээр, дур мэдэн өөр хэрэглэгчийг цэвэр усаар хангасан, хангагчийн эрх бүхий ажилтныг өөрийн барилга байгууламжид нэвтрэх боломж олгоогүй, хэвийн ажиллагааг алдагдуулах үйлдэл гаргасан зэргээс шалтгаалан тухайн зөрчил гаргасан хэрэглэгчийн цэвэр усны хэрэглээг хязгаарлах;

*3.2 Хангагчийн үүрэг*

3.2.1 Хангагч нь хүн амын унд-ахуйн стандартад тохирсон цэвэр усаар хэрэглэгчийг тасралтгүй найдвартай хангаж, MNS 6561-2015 стандартын шаардлага хангасан бохир усыг төвийн шугамд хүлээн авч татан зайлуулна;

3.2.2 Хангагч нь цэвэр усны шугамын даралтыг 2 ата-аас багагүй байлгах;

3.2.3 Хангагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой хэрэгцээт мэдээллээр хангах;

3.2.4 Усны тоолуурын найдвартай ажиллагааг хангах зорилгоор тоолуур суурилуулах, баталгаажуулах, шалгах, засварлах зэрэг үйлчилгээг үзүүлнэ;

3.2.5 Хэрэглэгчээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шуурхай барагдуулах;

3.2.6 Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх болон бусад хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;

3.2.7 Технологи үйл ажиллагаандаа уур хэрэглэж байгаа үйлдвэрүүдийн уурын конденсацын илүүдэл усны тооцоог уурын тоолуураар тооцон технологийн бохир усны хэрэглээн дээр нэмж тооцно;

3.2.8 Хангагч нь төв шугамын төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус таслалтын тухай хэрэглэгчид дараах байдлаар мэдээлэх. Үүнд:

3.2.9 Хангагч нь төв шугамын туршилт, ээлжит засварын ажлыг эрх бүхий байгууллагын баталсан графикийн дагуу явуулах бөгөөд уг төлөвлөгөөт таслалтын хугацааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд урьдчилан мэдээлэх;

3.2.10 Хангагч нь хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмжид хийх шаардлагатай засвар үйлчилгээний талаар зөвлөмж болон шаардах хуудас, албан бичгийг гэмтэл гарсан үед нь тухай бүр хэрэглэгчид өгч, засвар үйлчилгээний гүйцэтгэлд нь батлагдсан графикт зогсолттой уялдуулан хяналт тавих;

3.2.11 Хэрэглэгчийн гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хүсэлтийг үндэслэн тухай бүрд нь тодотголоор үндсэн гэрээний эх хувьд нь өөрчлөлт оруулж шийдвэрлэх;

3.2.12 Цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр хураамжид өөрчлөлт орвол мөрдөж эхлэхээс 15 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон өөрийн вэб сайтаар мэдээлж байх;

3.2.13 Дундын эзэмшлийн шугам сүлжээний засвар, үйлчилгээний зардлыг тухайн

хязгаарлуулсан тохиолдолд усны үйлчилгээний төлбөрөө бүрэн төлөх мөн ус хаалгаж, нээлгэсний төлбөрийг төлж, өр авлагын тооцоогүй болсон тохиолдолд хангагч ус хангамжийг нээж протокол хөтөлнө;

2.16 Жилд 3-аас дээш удаа дээрхи төрлийн протокол хөтлөгдсөн хэрэглэгч нь найдваргүй хэрэглэгчийн бүртгэлд бүртгэгдэж гэрээ цуцлах төлөвт шилжих бөгөөд гэрээ цуцлах тухай мэдэгдлийг 2 сарын өмнө хэрэглэгчид албан ёсоор мэдэгдэнэ;

2.17 Хангагч нь тухайн сарын усны үйлчилгээний төлбөртэй холбоотой мессежийг хэрэглэгч рүү илгээх бөгөөд төлбөр нь усны төлбөрийн нэхэмжлэл дээр нэмж тооцогдоно;

2.18 Тоолуур, тооцооны хэмжих хэрэгслийн эвдрэл гэмтэл нь хэрэглэгчээс шалтгаалаагүй, эсхүл тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлаж, баталгаажуулах зорилгоор шугамаас салгасан бол өмнөх 3 сард хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээний дунджаар тооцон зөвхөн 1 сар тооцоо хийнэ;

## ГУРАВ. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

*3.1 Хангагчийн эрх*

3.1.1 Хангагч нь хэрэглэгчийн үйлдвэрийн үйл ажиллагаа, технологи үйл ажиллагааны явцад гарч байгаа бохир усны найрлага, бохирдуулагч бодисын хэмжээ зэргээс хамааруулсан цэвэрлэгээний анхан шатны төхөөрөмжүүд, тунгаагуур болон бага оврын цэвэрлэх байгууламж байгаа эсэхийг хянаж шалгах, суурилуулахыг шаардах;

3.1.2 Хэрэглэгчийн үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагааны явцад гарч байгаа бохир уснаас сар бүр итгэмжлэгдсэн лабораториор дээж авахуулж шинжилгээ хийлгэн зөвшөөрөгдөх нормоос хэтэрсэн үзүүлэлтүүдийг бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар шаардлага тавих;

3.1.3 Хэрэглэгчийн усны тоолуурт тооцогдоогүй хэрэглэсэн цэвэр, бохир усны хэрэглээг нөхөн тооцох, төлбөрийг нэхэмжлэх;

3.1.4 Үйлдвэрүүдийн хаягдал усанд хийгдэж байгаа дээж шинжилгээний дүнтэй тогтмол танилцаж цаашид хийх ажил, арга хэмжээнд зөвлөгөө өгөх;

3.1.5 Технологийн бохир усаа Урьдчилан цэвэрлэх байгууламжийн татах шугамд нийлүүлж байгаа үйлдвэрүүдээс тухайн жилд оруулах түүхий эдийн оруулгын тоог баталгаажуулж авах, явцад нь хяналт тавих;

3.1.6 Хангагч нь хэрэглэгчийн тооцоо, судалгаа, саналыг үндэслэн бусад хэрэглэгчийг цэвэр, бохир усны шугамд холбох;

3.1.7 Хангагчийн эрх бүхий ажилтнууд нь ажлын шаардлагаар хэрэглэгчийн ус хангамжийн хэмнэлттэй, найдвартай ажиллагаа болон төлбөр тооцооны хэрэгслийн хэвийн байдалд үзлэг шалгалт хийх, мөн түүнчлэн хэрэглэгчийн цэвэр, бохир усны шугам, тоног төхөөрөмж нь технологи ажиллагааны шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор барилга байгууламжид хэрэглэгчийн холбогдох албан тушаалтныг байлцуулан нэвтрэх;

3.1.8 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хэрэглэгчээс шаардах, албан

цэвэр усны хэмжээтэй адилаар тооцно;

2.3 Хэрэглэгчийн хэрэглээнээс гарч байгаа бохир усны найрлага нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн 50 дугаар тогтоолоор батлагдсан MNS 6561:2015 "Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны найрлага"-ын зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд Монгол улсын Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын дагуу ус бохирдуулсны төлбөрийн хэмжээгээр нэмэлт төлбөр төлнө;

2.4 Зоогийн газар, баар, ресторан, цайны газар, мал нядалгаа, машин угаалгын газрууд нь "Бохир усан дахь өөх, тос баригч төхөөрөмж, Техникийн ерөнхий шаардлага" MNS 5975:2009 стандартын дагуу өөх, тос баригчийг суурилуулсан байна;

2.5 Машин угаалгын үйлчилгээ үзүүлж буй иргэн аж ахуйн нэгж байгууллагууд дахин ашиглах цэвэршүүлсэн усны стандарт, техникийн ерөнхий шаардлага" MNS 6734:2018 стандартыг баримтлан цэвэршүүлсэн усыг эргүүлэн ашиглах тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглана;

2.6 Урьдчилан цэвэрлэх байгууламжид хэрэглээнээс гарсан бохир усаа нийлүүлж буй үйлдвэрүүд нь "Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх технологийн хаягдал ус. Техникийн шаардлага" MNS 5582: 2006 стандартыг хангасан байна;

2.7 Хэрэглэгч нь технологийн бохир уснаас сар бүр батлагдсан графикийн дагуу хангагч байгууллагын Усны төв лабораториор шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулна;

2.8 Хэрэглэгч нь өөрсдийн технологийн үйл ажиллагаанд тохирсон урьдчилан цэвэрлэх байгууламжтай байна

2.9 Гуравдугаар циклд хамрагдаж байгаа хэрэглэгчийн усны тоолуурын заалтыг сар бүрийн 14-өөс 20-ны хооронд авах бөгөөд хангагч, хэрэглэгчийн төлөөлөгч хамтран хяналтын картанд харилцан гарын үсэг зурж, баталгаажуулсан байна;

2.10 Хангагч нь гуравдугаар циклийн хэрэглэгчийн усны төлбөрийн нэхэмжлэх болон тооцооны хуудсыг сар бүрийн 22-ны өдөр www.eus.mn сайтад байршуулж, төлбөрийн нэхэмжлэл гарсан тухай мессежийг хэрэглэгчийн гэрээнд тэмдэглэгдсэн утасны дугаарт илгээнэ;

2.11 Хангагч нь сар бүрийн 24-25-ны дотор хэрэглэгчийн төлбөр төлөх эцсийн хугацааг мессежээр сануулна;

2.12 Гуравдугаар циклийн хэрэглэгч нь төлбөрийн нэхэмжлэл www.eus.mn сайтад байршнаас хойш 7 хоногийн дотор буюу сар бүрийн 28-ны дотор усны үйлчилгээний төлбөрөө бүрэн төлсөн байна;

2.13 Хэрэглэгч 2.7-д заасан хугацаанд усны үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд алданги тооцож эхэлсэн тухай мессежийг илгээх бөгөөд Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дэх хэсэгт заасны дагуу алдангийг хоног тутамд төлөгдөөгүй мөнгөн дүнгийн 0.2 хувиар тооцно;

2.14 Хэрэглэгч усны үйлчилгээний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд буюу 3 ба түүнээс дээш сарын хугацаанд төлөөгүй тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр 29-ний өдрөөс ус хангамжийг хязгаарлах арга хэмжээг авна;

2.15 Хэрэглэгч нь усны үйлчилгээний төлбөрийн улмаас ус хангамжийг

БАТЛАВ
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

БАТЛАВ
ЛОРО ПЪЯНА МОНГОЛ ХХК - ИЙН
ЗАХИРАЛ А.БУЯНДЭЛГЭР

# БОЛОВСРУУЛАХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖИЙГ "ЦЭВЭР УСААР ХАНГАХ, ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УСЫГ ТАТАН ЗАЙЛУУЛАХ" ГЭРЭЭ

2020 оны 06 сарын 02 өдөр Хэрэглэгчийн бүртгэл № 26007800

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Нэг талаас УСУГ түүнийг төлөөлж А/41 тоот тушаалыг үндэслэн гэрээний инженер албан тушаалтай Ө.ДАШНЯМ цаашид "*хангагч*" гэх, нөгөө талаас ЛОРО ПЪЯНА МОНГОЛ ХХК - ийн ЗАХИРАЛ албан тушаалтай А.БУЯНДЭЛГЭР "хэрэглэгч" гэх нар нь Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13 дугаар зүйл болон бусад холбогдох хуулийг удирдлага болгон 2020/06/02 -ны өдрөөс эхлэн дор дурьдсан нөхцлийг биелүүлж ажиллахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулж байна.

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааг зохицуулах дүрэм нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
1.3 Гэрээнд тусгагдаж буй дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.
1.4 УЦБ - Урьдчилан цэвэрлэх байгууламж
1.5 НХБТГ - Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар
1.6 ХСУХАТАҮЗЗ - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл
1.7 БОАЖЯ - Байгаль орчин аялал жуулчлалын яам
1.8 "Урьдчилгаа төлбөр" гэж Захиалгын хуудсаар хэрэглэгдэх усны хэмжээг тооцож, батлагдсан тарифыг үндэслэн тогтоосон технологийн бохир усны төлбөрийн хэмжээ
1.9 "Захиалгын хуудас" гэж арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн төрөл, тоо ширхэг, түүнд хэрэглэх химийн бодис, цэвэр усны хэмжээ, үйлдвэрлэлийн үргэлжлэх хугацаа зэргийг тодорхойлсон маягт /Маягт дугаар/

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭХ ЦЭВЭР УС БОЛОН ТАТАН ЗАЙЛУУЛАХ БОХИР УСНЫ ХЭМЖЭЭ, ЧАНАР, НАЙРЛАГА, ТӨЛБӨР, ТООЦОО ХИЙХ

2.1 Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр ус болон хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан усны тоолуураар хэмжих ба хэрэглээг тоолуурын заалтыг үндэслэн тооцно. Тоолуурын заалтаар гарсан хэрэглэсэн цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон бусад түүнтэй холбогдох төлбөрийг "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн баталсан усны үйлчилгээний тарифыг мөрдлөг болгоно;
2.2 Хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг тухайн хэрэглэгчийн хэрэглэсэн

TSETSUUH

SINCE 1996

**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК**

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

**Огноо:** 2024 оны 11 сарын 18

**Гэрээний дугаар:** **Ш-24/**

**Хүлээн авагч:**
**“Цэцүүх Трейд” ХХК**

**Хаяг**: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/, Энхтайваны өргөн чөлөө 64/2 тоот “Цэцүүх” оффис, үйлчилгээний төв
**Утас**: +976 70179777, +976 70180632
**Цахим хаяг:** www.tsetsuuh.mn
**Регистрийн дугаар:** 2066521
**Цахим шуудан:** info@tsetsuuh.mn

**Үүсгэгч:**
**“Лоро Пъяна Монгол” ХХК**

**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уу дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж 41 тоот
**Утас:** +976 11342338, +976 11343529
**Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаа** 9019011059
**Регистрийн дугаар:** 2046238
**Цахим шуудан:** mongolia.office@loropiana.com

*цэвэрлэсэн байна.* Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

## Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь **2024** оны **11** сарын **18** өдрөөс **2025** оны **11** сарын **18** өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.

3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.

3.3. Энэхүү гэрээний №1-д хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.

3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлоно.

3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

3.6. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхэгийг гэрээний хавсралт №2-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.

3.7. Талууд гэрээ байгуулах үед үүсгэгч хүлээн авагчид нэг жилд үүсэх аюултай хог хаягдлын төлбөрийн 30 хувийг төлсөнөөр гэрээ баталгаажна.

3.8. Үүсгэгчийн эхний нийлүүлэлтээр шилжүүлсэн аюултай хог хаягдлын төлбөр гэрээ байгуулах үед төлсөн төлбөрөөс илүү гарсан бол урьд төлсөн төлбөрийг тооцуулж үүн дээр илүү гарсан төлбөрийг нэмж төлнө, бага бол дараагийн нийлүүлэлт дээр үлдсэн төлбөрөө хасч тооцуулна.

3.9. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.

3.10. Үүсгэгч нь шилжүүлсэн аюултай хог хаягдлын төлбөрийг хүлээн авагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор Цэцүүх трейд ХХК-ийн **Голомт банкны 1715132986** тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу төлнө.

3.11. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

## Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:

4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.

______________ Хуудсыг баталгаажуулсан: ______________

5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

## Зургаа. Өмчлөх эрх шилжих

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

## Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Найм. Давагдашгүй хүчин зүйл

_______________ Хуудсыг баталгаажуулсан: _______________

*"Цэцүүх Трейд" ХХК, "Лоро Пъяна Монгол" ХХК-ийн хооронд байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх 2024 оны 11 дүгаар сарын 18 -ны өдрийн Ш-24/....... тоот гэрээний Хавсралт № 01*

2024-2025онд ЛОРО ПЪЯНА МОНГОЛ ХХК-ИЙН ЖИЛД УСТГУУЛАХ АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

| **№** | **Тухайн сав баглаа агуулагдаж бодисын мэдээлэл** | **Аюултай хог хаягдлын савны төрөл** | **Жилд үүсэх тоо хэмжээ / ш, кг, тонн /** | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| 1 | Ноолуур угаах саван | Химийн хуванцар торх 200л | | 10ш= 90кг | 10ш= 90кг | 10ш= 90кг |
| 2 | Полиэлекролит | Химийн бодисын хаягдал хуванцав сав 25л | | 7ш= 14кг | 7ш= 14кг | 7ш= 14кг |

Хуудсыг баталгаажуулсан:

**“Лоро Пъяна Монгол” ХХК-н АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ МАРШРУТ БОЛОН ҮНИЙН САНАЛ**

| № | Машины марк даац | Нэг удаагийн тээвэрлэлтийн маршрут | Нийт км | Нэгж үнэ /төг/ | Нийт үнэ /төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Bongo frontier 1 тонн /тээврийн хэрэгсэл сонгох/<br><br>Тээвэрлэлт хийх давтамж: 1удаа | “Лоро Пъяна Монгол” ХХК-н захиалгын дагуу Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж 41 хаягтай байршлаас аюултай хог хаягдлыг тээвэрлэн /Төв аймаг Сэргэлэн сум 4-зөрлөг/ нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэх. | 2 талд нийт 110 км | 2400 төг | 264000 төг |
| | **Нийт дүн: 264000 төгрөг** | | | | |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Үүсгэгч талыг төлөөлж:**
“Лоро Пъяна Монгол ” ХХК-ийн
Үйлдвэрийн дарга
.............................. /Н.Алтансүх/

Суурин утас: (976) 11 342338
Гар утас: 99196416
Регистер:2046237
УБ гэрчилгээний дугаар: 9019011059
Химийн бодис ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийн дугаар: 0
Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж 41
Хог хаягдал үүсэх хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж 41
Email хаяг: mongolia.office@loropiana.com

**Хүлээн авагч талыг төлөөлж:**
Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн дарга
_______________ / Б.Дарамбазар /

Нягтлан бодогч
_______________ /Т.Буяндэлгэр
Суурин утас: : (976) 70189778
Факс: : (976) 70180632
Гар утас: 99057786
Регистер: 2066521
УБ гэрчилгээний дугаар: 9011026056
Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000007
Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Хуудсыг баталгаажуулсан:

## УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 31 53 47
Цахим шуудан: ubzaa@ulaanbaatar.mn
Цахим хуудас: www.ubservice.mn

2022.05.13 № 01/606
танай 2022.05.11-ны № 197/22 -т

"ЛОРО ПЪЯНА МОНГОЛ" ХХК-д

